



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО



МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2022 | X



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРОО

**МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН
ТАНИЛЦУУЛГА**

2022
10 сар

Улаанбаатар хот
2022

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах
тоглоом 

Валютын ханш 




© 2022

аппликейшнаас
СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network



/StatisticMGL

Лавлах утас



Цахим шуудан



I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.


- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.


- ... мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- - гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл

III. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

- мянга =1000
- сая =10⁶
- тэрбум =10⁹
- их наяд =10¹²
- мян. мянга
- % хувь
- мм миллиметр
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- м² метр квадрат
- дм² дециметр квадрат
- км² километр квадрат
- м³ метр куб
- га гектар
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- цн центнер
- т тонн
- Вт ватт
- кВт.ц киловатт цаг
- кал калори
- ккал килокалори
- Гкал гигакалори(=10⁹ калори)
- с секунд
- мин минут
- мкг/м³ микрограмм метр куб
- м/с метр секунд
- ш ширхэг
- х.д.х хэвлэлийн даралтат хуудас

-  Үүнээс гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



V. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернетэд холбогдсон байх ёстой/



VI. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернетэд холбогдсон байх ёстой/

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	3
Үндсэн үзүүлэлтүүд.....	6
I. Хөдөлмөр	9
I.II. Хөдөлмөрийн бүтээмж	20
II. Өрхийн орлого, зарлага	21
III. Дотоодын нийт бүтээгдэхүүн.....	28
IV. Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл	35
V. Төсөв	43
VI. Төлбөрийн тэнцэл	48
VII. Гадаад худалдаа	52
VIII. Хэрэглээний үнэ	58
VIII.I. Гадаад худалдааны нөхцлийн индекс	68
VIII.II. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ.....	69
VIII.III. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс	72
VIII.IV. Барилгын өртгийн индекс	74
IX. Газар тариалан	76
X. Барилга	79
XI. Дотоод худалдаа.....	83
XII. Зочид буудал, зоогийн газар	86
XIII. Аюулт үзэгдэл, осол	89
Хавсралт хүснэгтийн жагсаалт	91

БҮЛЭГ**ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН**

	Үндсэн үзүүлэлт /хүснэгт/	Д.Баасан
I	Хөдөлмөр	Н.Алтантүлхүүр
I.I	Хөдөлмөрийн бүтээмж	Ч.Уртнасан
II.	Өрхийн орлого, зарлага	Н.Хэнбиш
III.	Дотоодын нийт бүтээгдэхүүн	Б.Баярмаа
IV.	Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл	А.Мөнхцэцэг
V.	Төсөв	Ч.Мөнхтуул
VI.	Төлбөрийн тэнцэл	Л.Энхбаатар
VII.	Гадаад худалдаа	Л.Энхбаатар
VIII.	Хэрэглээний үнэ	Д.Батсүх Х.Хонгорзул Д.Мөнхтуул
VIII.I.	Гадаад худалдааны нөхцөлийн индекс	Д.Мөнхтуул
VIII.II.	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	Г.Ануужин
VIII.III.	Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс	Б.Энхтүвшин
VIII.IV.	Барилгын өртгийн индекс	Г.Ануужин
IX.	Газар тариалан	Х.Тэмүүлэн
X.	Барилга	Л.Шинэтуяа
XI.	Дотоод худалдаа	Э.Цэнд-Аюуш
XII.	Зочид буудал, зоогийн газар	Ч.Мөнхтуул
XIII.	Аюулт үзэгдэл, осол	Б.Уянгаа

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

Э.Сарангоо

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2020 I-X	2021 I-X	2022 I-X
Ажиллах хүч, жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар	мянган хүн	▼ 1 268.6 ^{-1.1}	▼ 1 226.8 ^{-3.3}	▲ 1 259.6 ^{2.7}
Ажиллагчид	мянган хүн	▲ 1 176.0 ^{1.8}	▼ 1 135.9 ^{-3.4}	▲ 1191.5 ^{4.9}
Ажилгүй хүн	мянган хүн	▼ 92.6 ^{-26.8}	▼ 90.9 ^{-1.8}	▼ 68.1 ^{-25.1}
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар	мянган хүн	▼ 881.4 ^{3.7}	▲ 893.8 ^{1.4}	▼ 866.9 ^{-3.0}
Ажиллах хүчний оролцооны түвшин, жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар	хувь	▼ 59.0 ^{-1.8}	▼ 57.9 ^{-1.9}	▲ 59.2 ^{2.2}
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар	хувь	▲ 54.7 ^{0.9}	▼ 53.6 ^{-2.0}	▲ 56.0 ^{4.5}
Ажилгүйдлийн түвшин, жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар	хувь	▼ 7.3 ^{-26.3}	▲ 7.4 ^{1.4}	▼ 5.4 ^{-27.0}
Нэг өрхийн сарын дундаж орлого, жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар	мянган төгрөг	▲ 1 512.7 ^{8.8}	▲ 1 636.4 ^{8.2}	▲ 1 814.7 ^{10.9}
Үүнээс: мөнгөн орлогын дүнд эзлэх хувь	хувь	▲ 92.3 ^{1.5}	92.3 ^{0.0}	▲ 92.9 ^{0.7}
Нэг өрхийн сарын дундаж зарлага, жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар	мянган төгрөг	▲ 1 531.9 ^{5.6}	▼ 1 494.7 ^{-2.4}	▲ 1 842.5 ^{23.3}
Үүнээс: мөнгөн зарлагын дүнд эзлэх хувь	хувь	▲ 92.4 ^{1.2}	▼ 91.6 ^{-0.9}	▲ 93.0 ^{1.5}
Нийгмийн даатгалын сангийн орлого	тэрбум төгрөг	▼ 1 575.6 ^{-20.9}	▲ 2 136.1 ^{35.6}	▲ 2 846.3 ^{33.2}
Нийгмийн даатгалын сангийн зарлага	тэрбум төгрөг	▲ 1 997.8 ^{10.2}	▲ 2 123.1 ^{6.3}	▲ 2 813.6 ^{32.5}
Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ	тэрбум төгрөг	▲ 1 804.2 ^{16.7}	▲ 1 913.8 ^{6.1}	▲ 2 528.8 ^{32.1}
Нийгмийн даатгалд даатгуулагчид	мянган хүн	▼ 1 090.1 ^{-1.0}	▲ 1 102.0 ^{1.1}	▲ 1 187.5 ^{7.8}
Амьд төрсөн хүүхэд	мянган хүн	▼ 63.8 ^{-2.3}	▼ 60.9 ^{-4.5}	▼ 54.1 ^{-11.2}
Амаржсан эх	мянган хүн	▼ 63.4 ^{-2.2}	▼ 60.4 ^{-4.7}	▼ 53.7 ^{-11.1}
Нас баралт	мянган хүн	▼ 13.4 ^{-6.3}	▲ 16.2 ^{20.9}	▼ 14.8 ^{-8.6}
Үүнээс: эмнэлэгт нас барсан	мянган хүн	▼ 3.8 ^{-5.0}	▲ 5.7 ^{50.0}	▼ 4.4 ^{-22.8}
Төрөхийн улмаас эндсэн эх	хүн	▲ 21 ^{40.0}	▲ 56 ^{2.7**}	▼ 18 ^{-67.9}
Нялхсын эндэгдэл	хүн	▲ 750 ^{-12.3}	▼ 698 ^{-6.9}	▼ 652 ^{-6.6}
Нялхсын эндэгдлийн түвшин (тайлант сар)	1000 амьд төрөлтөд ногдох	▼ 11 ^{-1.0}	▼ 13 ^{-1.0}	▼ 12 ^{-7.7}
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	хүн	▼ 917 ^{-11.1}	▼ 830 ^{-9.5}	▼ 820 ^{-1.2}
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (тайлант сар)	1000 амьд төрөлтөд ногдох	▼ 13 ^{-2.0}	▲ 15 ^{2.0}	15 ^{0.0}
Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид	мянган хүн	▼ 711.2 ^{-6.5}	▲ 737.7 ^{3.7}	▲ 851.1 ^{15.4}
Халдварт өвчнөөр өвчлөгчид	мянган хүн	▼ 28.1 ^{-21.9}	▲ 492.3 ^{17.5**}	▼ 307.8 ^{-37.5}
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	▼ 21 142 ^{-26.1}	▼ 20 253 ^{-4.2}	▲ 31 320 ^{54.6}
16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	▼ 99 ^{-34.0}	▼ 95 ^{-4.0}	▲ 145 ^{50.0}
Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ	тэрбум төгрөг	▲ 256.6 ^{48.0}	▼ 141.5 ^{-44.9}	▲ 275.0 ^{94.3}
Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт	тэрбум төгрөг	▲ 60.7 ^{79.6}	▲ 63.8 ^{5.1}	▲ 144.9 ^{2.3**}

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2020 I-X	2021 I-X	2022 I-X
Үүнээс: 18 хүртэлх насныхан	хүн	▼ 690 ^{-39.0}	▼ 670 ^{-2.9}	▲ 1 308 ^{95.2}
Дотоодын нийт бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар	тэрбум төгрөг	▼ 26 579.2 ^{-3.8}	▲ 29 577.2 ^{11.3}	▲ 35 234.0 ^{17.7}
Дотоодын нийт бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аргаар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар	тэрбум төгрөг	▼ 18 835.7 ^{-6.7}	▲ 19 509.7 ^{3.6}	▲ 20 265.0 ^{3.7}
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө, сарын эцэст	тэрбум төгрөг	▲ 959.8 ^{9.8}	▲ 1 087.4 ^{13.3}	▼ 1 005.9 ^{-7.5}
M1, сарын эцэст	тэрбум төгрөг	▼ 3 643.2 ^{-13.0}	▲ 5 687.7 ^{56.1}	▲ 6 046.2 ^{6.3}
M2, сарын эцэст	тэрбум төгрөг	▲ 22 785.3 ^{10.2}	▲ 27 071.5 ^{18.8}	▲ 27 254.8 ^{0.7}
Зээлийн өрийн үлдэгдэл, сарын эцэст	тэрбум төгрөг	▼ 17 215.5 ^{-5.4}	▲ 20 085.0 ^{16.7}	▲ 22 810.6 ^{13.6}
Үүнээс: Хугацаа хэтэрсэн зээл, сарын эцэст	тэрбум төгрөг	▲ 1 226.3 ^{28.7}	▼ 1 035.9 ^{-15.5}	▲ 1 227.8 ^{18.5}
Чанаргүй зээл, сарын эцэст	тэрбум төгрөг	▲ 2 004.1 ^{3.9}	▼ 1 975.7 ^{-1.4}	▲ 2 657.5 ^{34.5}
Гадаад валютын нэрлэсэн ханш, сарын дундаж: АНУ доллар	төгрөг	▲ 2 853.60 ^{6.6}	▼ 2 848.97 ^{-0.2}	▲ 3 369.90 ^{18.3}
Евро	төгрөг	▲ 3 369.56 ^{13.9}	▼ 3 305.51 ^{-1.9}	▲ 3 315.60 ^{0.3}
Юань	төгрөг	▲ 424.25 ^{12.4}	▲ 443.71 ^{4.6}	▲ 468.39 ^{5.6}
Рубль	төгрөг	▼ 36.77 ^{-11.7}	▲ 39.91 ^{8.5}	▲ 54.77 ^{37.2}
Валютын хадгаламж, сарын эцэст	тэрбум төгрөг	▲ 4 925.0 ^{52.7}	▼ 4 034.9 ^{-18.1}	▲ 4 646.3 ^{15.2}
Үнэт цаасны гүйлгээ	тэрбум төгрөг	▼ 37.7 ^{-72.4}	▲ 1 107.1 ^{29.4**}	▼ 367.6 ^{-66.8}
Арилжсан үнэт цаас	сая ширхэг	▼ 236.2 ^{-42.5}	▲ 541.1 ^{2.3**}	▼ 439.4 ^{-18.8}
Үнэт цаасны зах зээлийн ТОП-20 дундаж индекс, сарын эцэст	нэгж	▼ 17 458.1 ^{-6.2}	▲ 40 357.5 ^{2.3**}	▼ 33 951.3 ^{-15.9}
Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж	тэрбум төгрөг	▼ 7 556.3 ^{-14.6}	▲ 10 654.7 ^{41.0}	▲ 12 966.8 ^{21.7}
Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж	тэрбум төгрөг	▼ 5 391.7 ^{-17.1}	▲ 7 517.4 ^{39.4}	▲ 7 702.5 ^{2.5}
Орон нутгийн нийт орлого, тусламж	тэрбум төгрөг	▲ 2 582.5 ^{10.4}	▲ 2 960.9 ^{14.7}	▼ 2 340.3 ^{-21.0}
Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, цэвэр зээл	тэрбум төгрөг	▲ 10 815.3 ^{30.3}	▲ 12 202.8 ^{12.8}	▲ 13 985.7 ^{14.6}
Улсын төсвийн нийт зарлага, цэвэр зээл	тэрбум төгрөг	▲ 8 473.2 ^{29.5}	▲ 9 618.6 ^{13.5}	▼ 8 613.5 ^{-10.4}
Орон нутгийн нийт зарлага, цэвэр зээл	тэрбум төгрөг	▲ 2 329.2 ^{9.7}	▼ 2 231.2 ^{-4.2}	▼ 1 878.3 ^{-15.8}
Тэнцвэржүүлсэн тэнцэл	тэрбум төгрөг	▼ -3 259.0 ^{-6.0**}	▼ -1 548.1 ^{-52.5}	▼ -1 018.9 ^{-34.2}
Гадаад худалдааны нийт бараа эргэлт	сая америк доллар	▼ 10 423.1 ^{-10.1}	▲ 13 168.7 ^{26.3}	▲ 17 154.3 ^{30.3}
Үүнээс: Экспорт	сая америк доллар	▼ 5 986.1 ^{-8.3}	▲ 7 523.5 ^{25.7}	▲ 10 008.8 ^{33.0}
Импорт	сая америк доллар	▼ 4 437.0 ^{-12.4}	▲ 5 645.2 ^{27.2}	▲ 7 145.6 ^{26.6}
Гадаад худалдааны тэнцэл	сая америк доллар	▲ 1 549.1 ^{5.8}	▲ 1 878.4 ^{21.3}	▲ 2 863.2 ^{52.4}
Хэрэглээний үнийн индекс (өмнөх сартай харьцуулсан)	хувь	▲ 0.4 ^{0.1}	▲ 0.5 ^{0.1}	▲ 1.3 ^{0.8}


ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020 I-X	2021 I-X	2022 I-X
Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны эцэстэй харьцуулсан)	хувь	▼ 2.3 ^{-2.8}	▲ 10.3 ^{8.0}	▲ 10.9 ^{0.6}
Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны мөн үетэй харьцуулсан)	хувь	▼ 2.4 ^{-5.2}	▲ 10.4 ^{8.0}	▲ 14.5 ^{4.1}
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл	тэрбум төгрөг	▼ 13 206.4 ^{-11.2}	▲ 15 424.4 ^{16.8}	▲ 17 267.7 ^{12.0}
Үүнээс: Уул уурхай, олборлолт	тэрбум төгрөг	▼ 9 479.0 ^{-15.2}	▲ 10 877.5 ^{14.8}	▲ 12 187.0 ^{12.0}
Боловсруулах үйлдвэрлэл	тэрбум төгрөг	▼ 2 663.3 ^{-2.2}	▲ 3 339.4 ^{25.4}	▲ 3 787.0 ^{13.4}
Цахилгаан хий, уур, агааржуулалт	тэрбум төгрөг	▲ 953.9 ^{8.1}	▲ 1 072.1 ^{12.4}	▲ 1 135.1 ^{5.9}
Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	тэрбум төгрөг	▲ 110.1 ^{21.3}	▲ 135.3 ^{22.9}	▲ 158.5 ^{17.1}
Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	▼ 15 518.3 ^{-9.3}	▲ 20 978.8 ^{35.2}	▲ 23 235.4 ^{10.8}
Үүнээс: Уул уурхай, олборлолт	тэрбум төгрөг	▼ 11 135.4 ^{-13.7}	▲ 15 409.6 ^{38.4}	▲ 16 984.4 ^{10.2}
Боловсруулах үйлдвэрлэл	тэрбум төгрөг	▲ 3 313.0 ^{2.9}	▲ 4 359.1 ^{31.6}	▲ 4 953.0 ^{13.6}
Цахилгаан хий, уур, агааржуулалт	тэрбум төгрөг	▲ 958.0 ^{8.2}	▲ 1 071.0 ^{11.8}	▲ 1 136.2 ^{6.1}
Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	тэрбум төгрөг	▲ 113.0 ^{24.4}	▲ 139.0 ^{23.0}	▲ 161.9 ^{16.5}
Төмөр замын тээврийн орлого	тэрбум төгрөг	▲ 645.9 ^{10.1}	▲ 660.1 ^{2.2}	▼ 594.2 ^{-10.0}
Төмөр замаар тээсэн ачаа	мянган тонн	▲ 24 874.9 ^{7.7}	▲ 26 637.5 ^{7.1}	▼ 22 058.4 ^{-17.2}
Төмөр замын тээврээр зорчигчид	мянган хүн	▼ 1 891.9 ^{-23.6}	▲ 147.2 ^{-12.6**}	▲ 2 109.2 ^{14.3**}
Агаарын тээврийн орлого	тэрбум төгрөг	▼ 131.4 ^{-3.4**}	▲ 141.2 ^{7.5}	▲ 395.6 ^{2.8**}
Агаарын тээврээр тээсэн ачаа	тонн	▼ 2 175.4 ^{-2.2**}	▲ 3 757.2 ^{72.7}	▲ 10 278.8 ^{2.7**}
Агаарын тээврээр зорчигчид	мянган хүн	▼ 427.5 ^{-3.3**}	▼ 137.6 ^{-3.1**}	▲ 764.9 ^{5.6**}




ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, 2022 оны 3 дугаар улирлын байдлаар, мянган хүн

Өвгүмтэн




ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ = АЖИЛГҮЙ ХҮН + ЦАГ ХУГАЦААНААС ХАМААРСАН БҮРЭН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ + БОЛОМЖИТ АЖИЛЛАХ ХҮЧ

хөдөлмөрийн дутуу ашиглалт, 123.5



Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин



Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдаагүй байхыг ойлгоно.



Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 9.5 хувь болж, өмнөх улирлаас 1.9 нэгж хувиар буурлаа

Ажиллах хүчний судалгааны 2022 оны 3 дугаар улирлын дүнгээр улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны нийт хүн амын 1.3 сая нь **ажиллах хүч** байна.

ЗУРАГ 1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, 2022 оны 3 дугаар улиралд, мянган хүн



Ажиллах хүчний 1.3 (94.6%) сая нь **ажиллагчид** байна. Ажиллагчид өмнөх оны мөн үеэс 55.6 (4.9%) мянгаар, өмнөх улирлаас 26.6 (2.3%) мянгаар өссөн байна. Улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны хүн амын 866.9 (40.8%) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Тэдгээрийн 41.4 (4.8%) мянга нь цалин хөлс, орлого олох ажил хайх эсвэл хийх нөхцөл нь бүрдвэл ажиллах хүчний эгнээнд шилжихэд бэлэн байгаа боломжит ажиллах хүч байна.


Хөдөлмөрийн дутуу ашиглалтын 41.4 (33.5%) мянга нь **боломжит ажиллах хүч**, 68.1 (55.2%) мянга нь **ажилгүй хүн**, 14.0 (11.3%) мянга нь **цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид** байна.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт өмнөх оны мөн үеэс 29.9 (19.5%) мянгаар, өмнөх улирлаас 25.9 (17.3%) мянган хүнээр буурсан байна.

Ажилгүй хүн өмнөх оны мөн үеэс 22.8 (25.1%) мянгаар, өмнөх улирлаас 30.4 (30.8%) мянгаар буурсан байна. Ажилгүй хүний тоо өмнөх оны мөн үеэс 20-29 насны бүлэгт 11.4 мянгаар, 35-54 насны бүлэгт 12.0 мянгаар, өмнөх улирлаас 25-39 насны бүлэгт 16.9 мянгаар, 40-54 насны бүлэгт 14.3 мянгаар тус тус буурчээ.

Боломжит ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 12.8 (23.7%) мянгаар, өмнөх улирлаас 3.2 (7.3%) мянгаар буурсан байна. Боломжит ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 30-34 насны бүлэгт 7.6 мянгаар, 25-29 насны бүлэгт 5.6 мянгаар, өмнөх улирлаас 50-54 насны бүлэгт 4.5 мянгаар, 60-64 насны бүлэгт 2.0 мянгаар тус тус буурсан байна.

ЗУРАГ 2. АЖИЛЛАХ ХҮЧ, АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ, насны бүлгээр, 2022 оны 3 дугаар улиралд, хүнээр




Нийт ажиллагчдын 47.4 (4.0%) мянга нь сүүлийн 7 хоногт ажиллаагүй ч буцаж хийхээр хүлээгдэж байгаа /тогтмол хийдэг ажил/ цалин хөлс, орлого олох ажилтай ажиллагчид байгаа нь өмнөх оны мөн үеэс 15.0 (24.0%) мянгаар буурч, өмнөх улирлаас 12.7 (36.6%) мянгаар өссөн байна. Харин сүүлийн 7 хоногт ажиллаагүй ажиллагчдын 0.1 (0.3%) мянга нь үүсээд байгаа цар тахалтай холбоотой шалтгаанаар ажиллаагүй байгаа нь өмнөх оны мөн үеэс 17.3 (99.4%) мянгаар, өмнөх улирлаас 0.2 (66.7%) мянгаар тус тус буурчээ.

ХҮСНЭГТ 1. СҮҮЛИЙН 7 ХОНОГТ АЖИЛЛААГҮЙ Ч БУЦАЖ ХИЙХЭЭР ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ЦАЛИН ХӨЛС, ОРЛОГО ОЛОХ АЖИЛТАЙ АЖИЛЛАГЧИД, улирлаар

Он	Улирал	Сүүлийн 7 хоногт ажиллаагүй ч буцаж хийхээр хүлээгдэж байгаа ажилтай		Үүнээс цар тахалтай холбоотой	
		мян.хүн	хувь	мян.хүн	хувь
2020	I-II	65.7	5.6%	15.7	32.2%
	IV-VI	57.1	4.8%	19.6	34.3%
	VII-IX	56.8	4.8%	25.8	45.3%
	X-XII	156.4	13.9%	124.7	79.8%
2021	I-II	91.4	8.7%	59.0	64.6%
	IV-VI	114.0	10.3%	85.5	75.0%
	VII-IX	62.4	5.5%	17.4	27.9%
2022	X-XII	30.0	2.7%	4.5	14.9%
	I-II	36.6	3.2%	2.4	6.4%
	IV-VI	34.7	3.0%	0.3	0.9%
	VII-IX	47.4	4.0%	0.1	0.3%

ЗУРАГ 3. ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүнд эзлэх хувиар, 2022 оны 3 дугаар улиралд




Ажиллагчдыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад боловсруулах үйлдвэрлэлийн салбарынх 31.5 (38.1%), ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуурын салбарт 14.0 (5.0%) мянгаар өсөж, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын салбарт ажиллагчид 10.5 (12.1%) мянгаар, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарынх 6.2 (16.7%) мянгаар буурсан байна. Харин өмнөх улиралтай харьцуулахад ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуурын салбарт ажиллагчид 9.7 (3.4%) мянгаар, барилгын салбарынх 5.5 (6.6%) мянгаар өсөж, уул уурхай, олборлолтын салбарынх 6.0 (9.6%) мянгаар буурсан байна.

ХҮСНЭГТ 2. АЖИЛЛАГЧИД, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүнээр

Салбар	2021	2022	
	VII-IX	IV-VI	VII-IX
Дүн	1135.9	1164.9	1191.5
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	282.3	286.6	296.3
Уул уурхай, олборлолт	57.8	62.2	56.3
Боловсруулах үйлдвэрлэл	82.8	112.5	114.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	19.9	23.8	23.2
Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	6.1	7.2	4.5
Барилга	93.7	83.4	88.9
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	148.5	140.8	146.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	58.1	65.0	69.3
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	37.5	30.1	31.2
Мэдээлэл, холбоо	16.2	18.0	21.6
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	27.8	19.3	24.4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	2.5	3.6	1.6
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	13.9	13.8	17.5
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	18.8	14.9	12.9
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	87.2	79.0	76.7
Боловсрол	98.5	102.9	105.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	50.1	46.5	48.5
Урлаг, үзвэр, тоглоом наадам	6.5	16.8	12.6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	25.1	35.7	36.6
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	2.6	1.3	0.9
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	-	1.5	2.1

Ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс өсөхөд хөдөлмөр эрхлэлтийн статусын хувьд цалин хөлстэй түр ажиллагч (126.2 мянгаар), цалин хөлстэй тохиолдлын ажиллагч (30.5 мянгаар), цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн (10.1 мянгаар) тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 4. АЖИЛЛАГЧИД, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, өмнөх оны мөн үе болон өмнөх улиралтай харьцуулснаар, 2022 оны 3 дугаар улиралд, мянган хүнээр



Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг үнэлэх дөрвөн үзүүлэлтүүд өмнөх улиралтай харьцуулахад хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 1.9 нэгж хувиар, ажилгүйдлийн түвшин 2.4 нэгж хувиар, ажилгүй хүн болон цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийн нэгдсэн түвшин 1.8 нэгж хувиар, ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 2.5 нэгж хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 2.5 нэгж хувиар, ажилгүйдлийн түвшин 2.0 нэгж хувиар, ажилгүй хүн болон цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийн нэгдсэн түвшин 1.6 нэгж хувиар, ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 2.9 нэгж хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 3. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ, хүйсээр

Үзүүлэлт	2021 IV-VI			2022 IV-VI		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Хөдөлмөрийн дутуу ашиглалт, мянган хүн	153.4	76.6	76.8	123.5	66.1	57.4
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	8.3	4.6	3.7	14.0	7.7	6.3
Ажилгүй хүн	90.9	48.0	42.9	68.1	37.1	31.0
Боломжит ажиллах хүч	54.2	24.0	30.2	41.4	21.3	20.1
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, %	12.0	11.5	12.5	9.5	9.7	9.3
Ажилгүйдлийн түвшин, %	7.4	7.4	7.4	5.4	5.6	5.2
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, %	8.1	8.2	8.0	6.5	6.8	6.3
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, %	11.3	10.8	11.9	8.4	8.5	8.3

ЗУРАГ 5. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШИН, насны бүлгээр, 2022 оны 3 дугаар улиралд




Хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтүүдийг 15-24 насныхан (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд), 25-54 насныхан (ерөнхий ажиллах хүчний насныхан) болон 55-64 насныхан (тэтгэвэрт гарахад ойрхон байгаа) гэсэн насны бүлгээр харуулав.

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын үндсэн 4 үзүүлэлтүүдэд 15-24 насныхан буюу боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд дийлэнх нь байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин 2022 оны 3 дугаар улиралд 59.2 хувь болж, эрэгтэйчүүдийнх 66.4 хувь, эмэгтэйчүүдийнх 52.9 хувь байна. Ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх улирлаас 0.1 нэгж хувиар буурсан бол, өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар өссөн байна.

Хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувь буюу **хөдөлмөр эрхлэлтийн түвшин** 56.0 хувь болж, өмнөх улирлаас 1.3 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 2.4 нэгж хувиар өссөн байна. Хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүдийнх 62.7 хувь, эмэгтэйчүүдийнх 50.1 хувь байна.

ЗУРАГ 6. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, насны бүлгээр, хувиар, 2022 оны 3 дугаар улиралд



Ойлголт, тодорхойлолт

Үндэсний Статистикийн Хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал"-ыг 2019 оны 1 дүгээр сараас мөрдөж байна. Үүнтэй уялдуулан хөдөлмөрийн статистикийн үндсэн үзүүлэлтийн мэдээллийн гол эх үүсвэр болох Ажиллах хүчний судалгааг шинэ ойлголт тодорхойлолт, аргачлалын дагуу явуулж байна.

Хөдөлмөрийн насны хүн ам гэж 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна (*заалт 15, 65, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-н*).

Ажиллах хүч гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм (*заалт 11, 16, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-н*).

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас энэ **боломжит ажиллах хүчийг** тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр **өргөтгөсөн ажиллах хүч** илэрхийлэгдэнэ (*заалт 16,55, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-н*).

Ажиллагч гэж зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, **цалин хөлс, орлого олох зорилгоор** бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ. Хөдөлмөр эрхлэгчдийг ажлын байрандаа байгаа болон түр эзгүй байгаа гэж хоёр бүлэгт хувааж авч үзнэ (*заалт 27, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-н*).

Хөдөлмөр эрхлэлтийн статус гэж эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа тухайн ажиллагчийг ажиллаж байгаа эдийн засгийн нэгж (хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага эсэх) болон эрх мэдэл, ажил үүргээр нь ангилахыг ойлгоно.

Ажил олгогч гэж ашиг олох зорилгоор тогтмол хугацаанд нэг буюу түүнээс дээш хүнийг "цалин хөлстэй ажиллагч"-аар ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг ойлгоно. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагч гэдэгт ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй. Ажил олгогчдыг дотор нь аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогч (захирал, менежер) болон өрхийн зах зээлийн аж ахуйн нэгжийн ажил олгогч гэж хоёр ангилна.

Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч гэж ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол "цалин хөлстэй ажиллагч"-аар ажиллуулан, хувийн бизнесийнхээ үйл ажиллагаанд оролцуулж байгаа байгууллагын эзэн бүхий ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.

Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч гэж ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол "цалин хөлстэй ажиллагч"-аар ажиллуулж байгаа ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.

Цалин хөлстэй ажилтангүй бие даасан ажиллагч гэж өөрийн хөрөнгөөрөө бие даан, эсвэл бусадтай хамтран эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж, тухайн хугацаанд ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг ойлгоно. Ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй гэдэг нь өөрөөсөө, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүнээсээ өөр нэг ч хүн ажилчнаар авч ажиллуулаагүй байхыг ойлгоно. Эдгээр хөдөлмөр эрхлэгчдийг дотор нь цалин хөлстэй ажилтангүй аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч болон цалин хөлстэй ажиллагчгүй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч гэж хоёр ангилна.

Цалин хөлстэй ажилтангүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч гэж ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл хувь эзэмшигч, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж, байгууллагын (хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл, хоршоо) үйл ажиллагааг эрхэлж буй ажилч юм.

Цалин хөлстэй ажилтангүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч гэж ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг эрхэлж явуулдаг ажилч юм.

Гүйцэтгэх гэрээлэгч гэж эдийн засгийн өөр нэг нэгжид, эсвэл уг нэгжээр дамжуулаад бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх зорилгоор арилжааны шинжтэй гэрээ (хөдөлмөрийн бус) байгуулан ажиллаж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагч нь тухайн

эдийн засгийн нэгжийн цалин хөлстэй ажиллагч биш боловч ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэл, орлого болон зах зээлд гарах боломж зэрэг нь уг эдийн засгийн нэгжээс хамаардаг. Мөн эдгээр ажиллагч нь тэдний үйлдвэрлэлийн (бүтээмжтэй) үйл ажиллагаанд хяналт тавьж, хийж гүйцэтгэсэн ажлынх нь үр шимийг шууд хүртдэг эдийн засгийн өөр нэгжээс хараат, ашгийн төлөө ажиллагч юм.

Цалин хөлстэй ажиллагч гэж ажиллаж буй эдийн засгийн нэгжээ эзэмшдэггүй, үйл ажиллагааны шийдвэрт оролцохгүйгээр тухайн нэгжид албан болон албан бусаар хөдөлмөр эрхлэн, ажилласан цаг, хийж гүйцэтгэсэн ажлынхаа (зарим тохиолдолд хийж гүйцэтгэсэн ажлынхаа үйл ажиллагаа тус бүрт) эсвэл худалдаа, үйлчилгээ (тоо хэмээ, захиалгын тоогоор) үзүүлснийхээ төлбөр болгон мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаг ажиллагч юм. Цалинтай ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн гэрээний нөхцөл, хөдөлмөрийн харилцааны зохицуулалтаас нь хамаарч 4 ангилна.

Цалин хөлстэй байнгын ажиллагч гэж ажлын цагийн доод хэмжээгээр ажиллах нь хүлээн зөвшөөрөгдсөн, байнгын буюу тухайн эдийн засгийн нэгжид ажиллах насны дээд хязгаар, тэтгэвэрт гарах нас зэргээс бусад хөдөлмөр эрхлэлтийг зогсоох тодорхой хугацаа, нөхцөл заагдаагүйгээр хөдөлмөр эрхэлдэг ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно. Мөн ажилд ороод удаагүй, туршилтын хугацаандаа ажиллаж байгаа боловч цаашид үргэлжлүүлээд байнгын хугацаагаар ажиллуулахаар хүлээгдэж байгаа ажиллагч орно.

Цалин хөлстэй түр ажиллагч гэж хөдөлмөр эрхлэх хугацаа нь 3 ба түүнээс дээш сараар хязгаарлагдсан буюу тодорхой хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно.

Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч гэж ажлын тогтсон цаггүй, хөдөлмөр эрхлэлт нь 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлагдсан буюу богино хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм.

Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигчид гэж цалин хөлстэйгөөр, ажлын байрны болон мэргэжлийн хувьд дадлага, туршлага, ур чадвар эзэмших зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй ажиллагч юм.

Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн гэж өрхийн гишүүд, мөн өөр өрхөд амьдарч буй гэр бүлийн холбоотой (эцэг, эх, ах, дүү гэх мэт) хүмүүсийн эрхэлж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажилд, эсвэл тэдгээрийн цалинтай ажил болон гүйцэтгэх гэрээлэгчээр ажиллаж буй ажилд нь тусалж байгаа ажиллагчийг хэлнэ. Тэд эдийн засгийн нэгжийн үйл ажиллагаанд нь нөлөөлөх шийдвэр гаргадаггүй, үүрэг хүлээдэггүй бөгөөд цалин хөлсгүйгээр оролцож, үйл ажиллагаанаас олсон орлогоос өрх дотроо ашиг хүртдэг.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно (заалт 40, 42 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг дараах үзүүлэлтээр хэмжинэ. Үүнд:

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль

тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 40 цагаар авч үзнэ (заалт 43 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм (заалт 47 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

а. хөдөлмөр эрхлээгүй гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн ажил хийгээгүй, ажиллагч гэдэг тодорхойлолтод хамаарахгүй байхыг;

б. ажил хийхэд бэлэн гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт эсвэл тухайн хугацаанаас хойш ирэх хоёр долоо хоногт ажил хийж эхлэхэд бэлэн байхыг;

в. ажил хайж байгаа гэж сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн хүн юм. Ажил хайх гэдгийг ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлэх, ажлын байрны талаар мэдээлэл авч ажил олгогчтой холбогдсон, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих гэх мэт ажил олох оролдлого идэвхтэй хийхийг ойлгоно. Харин ажлын байрны талаар мэдээлэл авсан ч ажил олгогчид хандаагүй бол идэвхтэй оролдлого хийсэн гэж үзэхгүй.

Боломжит ажиллах хүч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм (заалт 40с, 51, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд:

а. Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа хүн;

б. Ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа хүн.

Тооцох аргачлал:

Ажиллах хүч: Тухайн хугацаанд хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүний тооны нийлбэрээр тооцно.

$$\text{Ажиллах хүч} = \text{Ажиллагчид} + \text{Ажилгүй хүн}$$

Өргөтгөсөн ажиллах хүч: Ажиллах хүч болон боломжит ажиллах хүчний тооны нийлбэрээр тооцно.

$$\text{Өргөтгөсөн ажиллах хүч} = \text{Ажиллах хүч} + \text{Боломжит ажиллах хүч}$$

Ажиллах хүчний оролцооны түвшин: Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Ажиллах хүчний оролцооны түвшин} = \frac{\text{Ажиллах хүч}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Ажиллагчдын тоог хөдөлмөрийн хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Хөдөлмөр эрхлэлтийн түвшин} = \frac{\text{Ажиллагчид}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин:

Ажилгүйдлийн түвшин: Ажилгүй хүний тоог ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-1).

$$\text{ХДАТ 1} = \frac{\text{Ажилгүй хүний тоо}}{\text{Ажиллах хүч}} * 100\%$$

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин: Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид болон ажилгүй хүний тооны нийлбэрийг ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-2).

$$\text{ХДАТ 2} = \frac{\text{Ажилгүй хүний тоо} + \text{ЦХХББХЭ}}{\text{Ажиллах хүч}} * 100\%$$

Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин: Боломжит ажиллах хүч болон ажилгүй хүний тооны нийлбэрийг өргөтгөсөн ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-3).

$$\text{ХДАТ 3} = \frac{\text{Ажилгүй хүний тоо} + \text{Боломжит ажиллах хүч}}{\text{Өргөтгөсөн ажиллах хүч}} * 100\%$$

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин: Хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу ажилгүй хүн, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч болон боломжит ажиллах хүчний тооны нийлбэрийг өргөтгөсөн ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-4).

$$\text{ХДАТ 4} = \frac{\text{Ажилгүй хүний тоо} + \text{ЦХХББХЭ} + \text{Боломжит ажиллах хүч}}{\text{Өргөтгөсөн ажиллах хүч}} * 100\%$$






Нэг ажиллагчид ногдох ДНБ, 2022 оны 3 дугаар улиралд 2.4 хувиар өслөө


Нэг ажиллагчид ногдох ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2022 оны 3 дугаар улиралд 6.0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 139.0 (2.4%) мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 7. НЭГ АЖИЛЛАГЧИД НОГДОХ ДНБ, улирлаар, сая төгрөгөөр



Томсгосон 4 салбараар авч үзвэл, нэг ажиллагчид ногдох ДНБ буюу хөдөлмөрийн бүтээмж 2022 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс хөдөө аж ахуйн салбар, уул уурхай олборлолтын салбар, үйлчилгээний салбар өссөн бол аж үйлдвэр, барилгын салбарт буурсан байна.

ЗУРАГ 8. НЭГ АЖИЛЛАГЧИД НОГДОХ ДНБ, салбараар, сая төгрөгөөр



Хөдөө аж ахуйн салбарын нэг ажиллагчид ногдох нэмэгдэл өртөг 4.0 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 114.1 (2.9%) мянган төгрөгөөр, үйлчилгээний салбарынх 5.1 сая төгрөг болж, 216.9 (4.5%) мянган төгрөгөөр, уул уурхай, олборлолтын салбарынх 17.5 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 805.2 (4.8%) мянган төгрөгөөр нэмэгдсэн бол аж

үйлдвэр, барилгын салбарынх 3.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 127.4 (3.3%) мянган төгрөгөөр буурчээ.

Ойлголт, тодорхойлолт:

Бүтээмж нь улс оронд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлт бөгөөд үйлдвэрлэл (гарц), орцын харьцаагаар тодорхойлно. Хөдөлмөрийн бүтээмж нь нэг ажиллагчид ногдох бодит ДНБ-ээр хэмжигдэнэ. Хөдөлмөрийн бүтээмжийн тооцоонд ашиглаж буй ДНБ-д өөрийн эзэмшлийн орон сууцны хийсвэр түрээсийг тусгаагүй болно.






ӨРХИЙН МӨНГӨН ОРЛОГЫН БҮЛЭГЛЭЛТ,

2022 оны 3 дугаар улиралд

Өрхийн мөнгөн орлого, зарлага

Мөнгөн орлогын бүлэг



2021 VII-IX	Өөрчлөлт	2022 VII-IX
63.0	6.9	113.7
134.3	14.7	142.6
144.4	15.8	137.1
201.0	22.0	190.2
98.7	10.8	95.1
92.3	10.1	74.6
80.4	8.8	79.2
83.1	9.1	77.4
16.5	1.8	22.4

Төрөл	Өөрчлөлт
3 000 001 төгрөгөөс дээш	↑ 12.2
2 100 001 - 3 000 000	↑ 15.3
1 600 001 - 2 100 000	↑ 14.7
1 100 001 - 1 600 000	↓ 20.4
900 001 - 1 100 000	↓ 10.2
700 001 - 900 000	↓ 8.0
500 001 - 700 000	↓ 8.5
300 001 - 500 000	↓ 8.3
300 000 төгрөг хүртэл	↓ 2.4



Өрхийн сарын дундаж бодит нийт орлого өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар буурлаа

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2022 оны 3 дугаар улирлын дүнгээр өрхийн сарын дундаж нийт орлого, оны үнээр 1.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 178.3 (10.9%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 27.2 (1.5%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

ЗУРАГ 9. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, мянган төгрөгөөр



Нэг өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит нийт орлогын хэмжээ 2022 оны 3 дугаар улиралд 1.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 28.8 (2.4%) мянган төгрөгөөр буурч, өмнөх улирлаас 19.6 (1.7%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Бодит нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар буурахад тэтгэвэр, тэтгэмжийн бодит орлого 65.4 (19.3%) мянган төгрөгөөр буурсан нь гол нөлөө үзүүлжээ (Зураг 1).

ХҮСНЭГТ 4. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, оны үнээр

Орлогын төрөл	2021 VII-IX	2022		2022 VII-IX	2022 VII-IX
		IV-VI	VII-IX	2021 VII-IX	2022 IV-VI
	төгрөг			хувь	
Нийт орлого	1 636 403	1 787 503	1 814 676	110.9	101.5
1. Мөнгөн орлого	1 510 418	1 651 549	1 686 591	111.7	102.1
Цалин хөлс	733 815	829 358	873 559	119.0	105.3
Тэтгэвэр, тэтгэмж	461 675	432 577	423 294	91.7	97.9
ХАА-н үйлдвэрлэлийн орлого	133 734	137 334	121 496	90.8	88.5
ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	73 863	93 341	110 507	149.6	118.4
Бусад орлого	107 331	158 939	157 735	147.0	99.2
2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	40 377	53 900	56 972	141.1	105.7
3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	85 608	82 054	71 113	83.1	86.7

Өрхийн сарын дундаж мөнгөн орлого, оны үнээр 2022 оны 3 дугаар улиралд 1.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 176.2 (11.7%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Үүнд цалин хөлсний орлого 139.7 (19.0%) мянган төгрөгөөр, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 36.6 (49.6%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Өрхийн сарын дундаж мөнгөн орлого өмнөх улирлаас 35.0 (2.1%) мянган төгрөгөөр нэмэгдэхэд цалин хөлсний орлого 44.2 (5.3%) мянган төгрөгөөр, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 17.2 (18.4%) мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ (Хүснэгт 1).

ЗУРАГ 10. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, 2022 оны 3 дугаар улирлын байдлаар, улсын дунджаар



Өрхийн сарын дундаж мөнгөн орлогод цалин хөлсний орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.2 нэгж хувиар, бусад орлогын эзлэх хувь 2.3 нэгж хувиар, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын эзлэх хувь 1.6 нэгж хувиар нэмэгдэж, харин тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь 5.5 нэгж хувиар, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлогын эзлэх хувь 1.6 нэгж хувиар буурсан байна (Зураг 2)

Өрхүүдийг мөнгөн орлогоор нь бүлэглэн авч үзэхэд 2022 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 300.0-500.0 мянган төгрөгийн орлоготой өрх 5.7 мянгаар, 500.0-700.0 мянган төгрөгийн орлоготой өрх 1.2 мянгаар, 700.0-900.0 мянган төгрөгийн орлоготой өрх 17.7 мянгаар, 900.0-1100.0 мянган төгрөгийн орлоготой өрх 3.6 мянгаар, 1.1-1.6 сая төгрөгийн орлоготой өрх 10.8 мянгаар, 1.6-2.1 сая төгрөгийн орлоготой өрх 7.3 мянгаар буурсан бол, 300.0 мянган төгрөгөөс доош орлоготой өрх 5.9 мянгаар, 2.1-3.0 сая төгрөгийн орлоготой өрх 8.3 мянгаар, 3.0 сая төгрөгөөс дээш орлоготой өрх 50.7 мянгаар тус тус нэмэгдсэн байна (Хүснэгт 2).

ХҮСНЭГТ 5. МӨНГӨН ОРЛОГЫН БҮЛЭГЛЭЛТ, өрхийн дүнд эзлэх хувь, мянган өрхөөр

Мөнгөн орлогын бүлэг	2021 VII-X		2022 IV-VI		2022 VII-X	
	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь
300 000 төгрөг хүртэл	16.5	1.8	19.5	2.1	22.4	2.4
300 001 - 500 000	83.1	9.1	76.0	8.2	77.4	8.3
500 001 - 700 000	80.4	8.8	71.4	7.7	79.2	8.5
700 001 - 900 000	92.3	10.1	88.1	9.5	74.6	8.0
900 001 - 1 100 000	98.7	10.8	92.7	10.0	95.1	10.2
1 100 001 - 1 600 000	201.0	22.0	191.1	20.6	190.2	20.4
1 600 001 - 2 100 000	144.4	15.8	143.8	15.5	137.1	14.7
2 100 001 - 3 000 000	134.3	14.7	143.8	15.5	142.6	15.3
3 000 001 төгрөгөөс дээш	63.0	6.9	101.1	10.9	113.7	12.2

Улсын хэмжээнд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар сард 500.0-900.0 мянган төгрөгийн мөнгөн орлоготой өрхийн дундаж орлогын 55.9 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.4 нэгж хувиар буурсан байна.


ХҮСНЭГТ 6. МӨНГӨН ОРЛОГЫН БҮЛЭГЛЭЛТ, төгрөгөөр

Мөнгөн орлогын бүлэг		Дундаж мөнгөн орлого	Цалин хөлс	Тэтгэвэр, тэтгэмж	ХАА-н үйлдвэрлэлийн орлого	ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	Бусад орлого
2021 VII-IX	500 000 төгрөг хүртэл	379 347	24 283	283 937	43 500	3 153	24 474
	500 001 - 900 000	705 102	122 136	432 485	95 067	7 597	47 817
	900 001 - 1 600 000	1 226 759	498 379	493 000	122 313	55 674	57 393
	1 600 001 төгрөгөөс дээш	2 499 559	1 458 704	501 178	189 856	144 158	205 663
2022 VII-IX	500 000 төгрөг хүртэл	378 674	29 894	274 604	46 646	11 399	16 131
	500 001 - 900 000	704 819	152 597	393 663	83 652	22 580	52 327
	900 001 - 1 600 000	1 230 349	508 803	488 788	118 659	50 375	63 724
	1 600 001 төгрөгөөс дээш	2 729 380	1 631 508	424 805	157 148	213 324	302 595

Судалгааны 2022 оны 3 дугаар улирлын дүнгээр өрхийн сарын дундаж нийт зарлага, оны үнээр 1.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 347.8 (23.3%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 31.3 (1.7%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

ЗУРАГ 11.НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, мянган төгрөгөөр

- Өрхийн сарын дундаж нийт зарлага, оны үнээр
- Өрхийн сарын дундаж нийт зарлага, 2015 оны зэрэгцүүлэх үнээр




Нэг өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит нийт зарлагын хэмжээ 2022 оны 3 дугаар улиралд 1.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 93.2 (8.5%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 22.3 (1.9%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Бодит нийт зарлагын хэмжээ өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар нэмэгдэхэд хүнсний бус бараа, үйлчилгээний бодит зарлага 56.9 (8.4%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ (Зураг 3).

Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага, оны үнээр 2022 оны 3 дугаар улиралд 1.7 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 345.7 (25.3%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 39.2 (2.3%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага өмнөх оны мөн үеэс нэмэгдэхэд хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 213.4 (23.2%) мянган төгрөгөөр, хүнсний бүтээгдэхүүний зарлага 68.0 (21.9%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ (Хүснэгт 4).

ХҮСНЭГТ 7. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, оны үнээр

Зарлагын төрөл	2021 VII-IX	2022		2022 VII-IX	2022 VII-IX
		IV-VI	VII-IX	2021 VII-IX	2022 IV-VI
	төгрөг	хувь			
Нийт зарлага	1 494 744	1 811 229	1 842 513	123.3	101.7
1. Мөнгөн зарлага	1 368 759	1 675 275	1 714 428	125.3	102.3
Хүнсний бүтээгдэхүүний зарлага	310 784	391 561	378 739	121.9	96.7
Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	920 225	1 096 590	1 133 629	123.2	103.4
Бусад зарлага	108 654	157 371	171 135	157.5	108.7
Бусдад өгсөн бэлэг, тусламж	29 096	29 753	30 925	106.3	103.9
2. Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн	40 377	53 900	56 972	141.1	105.7
3. Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн	85 608	82 054	71 113	83.1	86.7

ЗУРАГ 12. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, 2022 оны 3 дугаар улирлын байдлаар, улсын дунджаар



Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагад хүнсний бүтээгдэхүүний зарлагын эзлэх хувь 2022 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар, хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын эзлэх хувь 1.1 нэгж хувиар, бусдад өгсөн бэлэг, тусламжийн зарлагын эзлэх хувь 0.3 нэгж хувиар буурч, харин бусад зарлагын эзлэх хувь 2.0 нэгж хувиар нэмэгдсэн байна (Зураг 4).

Өрхийн хүнсний бүтээгдэхүүний сарын дундаж зарлагын 30.8 хувийг мах, махан бүтээгдэхүүн, 23.4 хувийг үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн, 10.7 хувийг сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, 8.7 хувийг хүнсний ногоо, булцуут, навчит ургамал эзэлж байна.

ХҮСНЭГТ 8. ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, гол нэр төрлөөр, төгрөгөөр

Хүнсний бүтээгдэхүүний гол нэр төрөл	2021 VII-IX	2022 IV-VI	2022 VII-IX
Мах, махан бүтээгдэхүүн	111 735	127 626	116 600
Үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн	72 325	88 293	88 775
Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг	35 499	45 308	40 646
Хүнсний ногоо, булцуут, навчит ургамал	24 778	34 402	33 080
Цэвэр ус, ундаа, жимсний шүүс	10 039	16 493	16 391
Элсэн чихэр, чихэрлэг бүтээгдэхүүн, амттан	11 011	15 537	16 305
Жимс, самар	10 958	13 189	14 705
Төрөл бүрийн өөх, тос	8 439	10 887	11 559
Цай, кофе	4 898	6 943	7 632

Мөн хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын 12.3 хувийг бэлэн хувцас, гутал, 11.0 хувийг тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар, үйлчилгээ, 5.7 хувийг эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээний зардал, 5.6 хувийг харилцаа холбооны үйлчилгээ, 4.8 хувийг боловсролын зардал эзэлж байна.

ХҮСНЭГТ 9. ХҮНСНИЙ БУС БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, гол нэр төрлөөр, төгрөгөөр

Хүнсний бус бараа, үйлчилгээний гол нэр төрөл	2021 VII-IX	2022 IV-VI	2022 VII-IX
Тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар	75 181	98 818	107 705
Бэлэн хувцас	71 603	81 568	90 555
Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээ	52 832	65 223	64 970
Харилцаа холбооны үйлчилгээ	57 143	65 005	63 916
Боловсрол	49 155	47 470	54 207
Гутал, хос	37 849	43 476	48 545
Чөлөөт цаг болон соёлын үйлчилгээ	24 603	29 214	35 516
Сууцны төлбөр	22 738	24 876	29 270
Түлш	25 208	26 444	27 378
Тээврийн үйлчилгээ	12 236	15 881	16 629
Цахилгаан	9 305	6 702	10 851

Өрхүүдийг мөнгөн зарлагаар нь бүлэглэн авч үзэхэд 2022 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 300.0 мянган төгрөгөөс доош зарлагатай өрх 10.7 мянгаар, 300.0-500.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 28.0 мянгаар, 500.0-700.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 26.7 мянгаар, 700.0-900.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 7.3 мянгаар, 900.0-1100.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 11.8 мянгаар, 1.1-1.6 сая төгрөгийн зарлагатай өрх 6.0 мянгаар буурсан бол, 1.6-2.1 сая төгрөгийн зарлагатай өрх 7.2 мянгаар, 2.1-3.0 сая төгрөгийн зарлагатай өрх 30.9 мянгаар, 3.0 сая төгрөгөөс дээш зарлагатай өрх 71.0 мянгаар тус тус нэмэгдсэн байна (Хүснэгт 7).

ХҮСНЭГТ 10. МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮЛЭГЛЭЛТ, өрхийн дүнд эзлэх хувь, мянган өрхөөр

Мөнгөн зарлагын бүлэг	2021 VII-IX		2022 IV-VI		2022 VII-IX	
	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо /мянган өрх/	Дүнд эзлэх хувь
300 000 төгрөг хүртэл	24.7	2.7	14.8	1.6	14.0	1.5
300 001 - 500 000	89.5	9.8	60.3	6.5	61.5	6.6
500 001 - 700 000	108.7	11.9	83.5	9.0	82.0	8.8
700 001 - 900 000	103.3	11.3	100.2	10.8	96.0	10.3
900 001 - 1 100 000	106.9	11.7	96.5	10.4	95.1	10.2
1 100 001 - 1 600 000	207.4	22.7	204.1	22.0	201.4	21.6
1 600 001 - 2 100 000	124.3	13.6	132.6	14.3	131.5	14.1
2 100 001 - 3 000 000	95.9	10.5	126.1	13.6	126.8	13.6
3 000 001 төгрөгөөс дээш	53.0	5.8	109.4	11.8	124.0	13.3

Сард 500.0-900.0 мянган төгрөг хүртэлх мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлагын бүтцийг авч үзэхэд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар дундаж зарлагын 32.1 хувийг хүнсний бүтээгдэхүүний зарлага эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 11. МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮЛЭГЛЭЛТ, төгрөгөөр

Мөнгөн зарлагын бүлэг		Дундаж мөнгөн зарлага	Хүнсний бүтээгдэхүүний зарлага	Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага	Бусад зарлага	Бусад өгсөн бэлэг, тусламж
2021 VII-X	500 000 төгрөг хүртэл	370 470	126 282	185 853	51 762	6 573
	500 001 - 900 000	700 875	214 779	382 669	86 127	17 300
	900 001 - 1 600 000	1 221 790	325 846	765 824	109 459	20 661
	1 600 001 төгрөгөөс дээш	2 471 975	444 776	1 820 960	148 899	57 340
2022 VII-X	500 000 төгрөг хүртэл	380 005	131 863	161 316	78 630	8 196
	500 001 - 900 000	712 929	228 877	352 791	119 052	12 209
	900 001 - 1 600 000	1 227 895	338 988	708 862	159 524	20 521
	1 600 001 төгрөгөөс дээш	2 824 176	528 441	2 020 714	222 775	52 246

Ойлголт, тодорхойлолт:

Өрх: Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээт зүйлсээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүс болон ганц биеэрээ өрх болон амьдардаг хүнийг хэлнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн, хамаатан садны холбоотой, бүх гишүүд болон зарим гишүүд нь огт хамааралгүй эсвэл эдгээрийн аль алинаас бүрдсэн байж болно.

Өрхийн мөнгөн орлого: Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого болон бусад орлогоос бүрдэнэ.

Өрхийн мөнгөн зарлага: Хүнсний бүтээгдэхүүн, хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад өгсөн бэлэг, тусламж, бусад зарлага багтана.







ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН (ДНБ)

2022 оны эхний 9 сард

Монгол Улсын эдийн засаг 2022 оны эхний 9 сард



хөдөө аж ахуй



уул уурхай, олборлолт




АЖ ҮЙЛДВЭР², БАРИЛГА



ҮЙЛЧИЛГЭЭ




БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЦЭВЭР ТАТВАР



Өсөлт, бууралт
Оролцоо, нэгж хувиар

ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААРХ ДНБ-ИЙ БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар



² Уул уурхай, олборлолтын салбар ороогүй




ДНБ, 2022 оны эхний 9 сард 3.7 хувиар өслөө


ДНБ, үйлдвэрлэлийн аргаар

Дотоодын нийт бүтээгдэхүүн (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2022 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 35.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.3 (17.7%) их наяд төгрөгөөр өссөн бол 2015 оны зэрэгцүүлэх үнээр 20.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 730.0 (3.7%) тэрбум төгрөгөөр өслөө.

ЗУРАГ 13. ДНБ-ИЙ ХЭМЖЭЭ, их наяд төгрөгөөр




ЗУРАГ 14. ДНБ-ИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, хувиар (2015 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх оны мөн үеэс)



ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 оны эхний 9 сард 6.7 хувиар буурсан бол 2021, 2022 оны эхний 9 сард 3.7 хувиар тус тус өслөө.

ЗУРАГ 15. ДНБ (УЛИРЛЫН НӨЛӨӨЛЛИЙГ АРИЛГАСАН)-ИЙ ЦЭВЭР ӨСӨЛТ, БУУРАЛТ, хувиар, өмнөх улирлаас




Улирлын нөлөөллийг арилган тооцсон, ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2022 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас 1.0 хувиар өслөө.

ХҮСНЭГТ 12. ДНБ-ИЙ ӨӨРЧЛӨЛТӨД САЛБАРУУДЫН ОРОЛЦОО, нэгж хувиар


Үзүүлэлт	2019 I-IX	2020 ¹ I-IX	2021 ¹ I-IX	2022* I-IX	
ДНБ-ий өсөлт, бууралт, %	6.8	-6.7	3.7	3.7	ДНБ, 2022 оны эхний 9 сард 3.7 хувиар өссөний
Хөдөө аж ахуй	0.2	1.6	-0.8	1.6	1.6 нэгж хувийг хөдөө аж
Уул уурхай, олборлолт	1.0	-3.3	1.3	-2.3	ахуйн салбар, -2.3 нэгж
Аж үйлдвэр, барилга	0.7	-0.4	-0.3	0.3	хувийг уул уурхай,
Боловсруулах	0.2	-0.4	0.4	0.1	олборлолтын салбар, 0.3
Цахилгаан, хий, уур, усан хангамж	0.1	0.0	0.2	0.1	нэгж хувийг аж үйлдвэр,
Барилга	0.4	-0.1	-0.9	0.1	барилгын салбар, 2.4 нэгж
Үйлчилгээ	3.6	-3.4	1.6	2.4	хувийг үйлчилгээний
Бөөний, жижиглэн худалдаа	1.5	-1.6	0.5	1.1	салбар, 1.7 нэгж хувийг
Тээвэр	0.5	-1.1	0.0	-0.1	бүтээгдэхүүний цэвэр
Мэдээлэл, холбоо	0.3	0.1	0.4	0.2	бүтээгдэхүүний цэвэр
Үйлчилгээний бусад	1.4	-0.8	0.6	1.1	татвар бүрдүүлсэн байна.
Бүтээгдэхүүний цэвэр татвар	1.4	-1.1	1.9	1.7	

ЗУРАГ 16. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ, өмнөх оны мөн үеэс, хувиар




Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2022 оны эхний 9 сард 3.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 310.9 (10.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь ДНБ-ий өөрчлөлтөд 1.6 нэгж хувиар эерэг нөлөө үзүүлсэн байна.

ЗУРАГ 17. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ, өмнөх оны мөн үеэс, хувиар




Уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2022 оны эхний 9 сард 2.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 444.9 (17.3%) тэрбум төгрөгөөр буурлаа. Энэхүү бууралтад нүүрс олборлолт 11.9 хувиар, газрын тосны олборлолт 66.9 хувиар, зэсийн баяжмал 12.1 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 18. АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ
ӨРТГИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ, өмнөх оны мөн үеэс, хувиар



Аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2022 оны эхний 9 сард 2.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 63.4 (2.9%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд барилгын салбарын нэмэгдэл өртөг 3.7 хувиар өссөн нь нөлөөлжээ.

ЗУРАГ 19. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН НЭМЭГДЭЛ
ӨРТГИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ, өмнөх оны мөн үеэс, хувиар



Үйлчилгээний салбарын нийт нэмэгдэл өртөг (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2022 оны эхний 9 сард 9.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 474.1 (5.3%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд бөөний болон жижиглэн худалдааны салбарын нэмэгдэл өртөг 11.3 хувиар, мэдээлэл, холбооны салбарын нэмэгдэл өртөг 8.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.


ДНБ, эцсийн ашиглалтын арга

ДНБ (эцсийн ашиглалтын аргаар тооцсон) оны үнээр 2022 оны эхний 9 сард 37.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.3 (20.2%) их наяд төгрөгөөр өслөө.

ХҮСНЭГТ 13. ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААРХ ДНБ, оны үнээр

Бүрэлдэхүүн	2019	2020 ¹	2021 ¹	2022*	2022*
	I-X	I-X	I-X	I-X	2021 ¹
	тэрбум төгрөг				хувь
ДНБ	27 399.3	27 279.3	30 906.4	37 163.5	120.2
Эцсийн хэрэглээ	19 335.7	21 321.8	20 426.3	24 480.5	119.8
Өрхийн хэрэглээ ²	15 886.2	17 281.0	16 680.6	20 414.8	122.4
Төрийн байгууллагын хэрэглээ	3 449.4	4 040.7	3 745.7	4 065.7	108.5
Хөрөнгийн нийт хуримтлал	8 784.6	6 430.9	12 197.2	16 100.6	132.0
Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	7 657.3	6 931.2	8 055.4	9 065.4	112.5
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт ³	1 127.3	- 500.3	4 141.8	7 035.2	169.9
Цэвэр экспорт	- 721.0	- 473.3	-1 717.1	-3 417.6	199.0
Бараа, үйлчилгээний экспорт	17 490.7	14 707.7	17 165.6	22 765.6	132.6
Бараа, үйлчилгээний импорт (-)	18 211.7	15 181.0	18 882.7	26 183.2	138.7

ЗУРАГ 20. ДНБ-ИЙ БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, эцсийн ашиглалтын аргаар



ДНБ-ий 2022 оны эхний 9 сард эцсийн хэрэглээнд 65.9 хувь, хөрөнгийн нийт хуримтлалд 43.3 хувь, цэвэр экспорт -9.2 хувь (үүнээс экспортод 61.3 хувь, импортод 70.5 хувь) зарцуулагдаж, өмнөх оны мөн үеэс хөрөнгийн нийт хуримтлал 3.8 нэгж хувиар нэмэгдэж, эцсийн хэрэглээ -0.2 нэгж хувиар, цэвэр экспорт -3.6 нэгж хувиар буурчээ.

ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр, эцсийн ашиглалтын аргаар тооцсон) 2022 оны эхний 9 сард 20.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 724.2 (3.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


ХҮСНЭГТ 14. ДНБ-ИЙ ӨӨРЧЛӨЛТӨД БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙН ОРОЛЦОО, нэгж хувиар

Бүрэлдэхүүн	2019 I-IX	2020 ¹ I-IX	2021 ¹ I-IX	2022* I-IX
ДНБ-ий өсөлт, бууралт, %	7.1	-6.0	3.4	3.7
Эцсийн хэрэглээ	5.7	5.8	-7.6	5.3
Өрхийн хэрэглээ ²	3.9	3.9	-6.1	4.7
Төрийн байгууллагын хэрэглээ	1.8	1.9	-1.4	0.6
Хөрөнгийн нийт хуримтлал	0.0	-11.1	20.9	9.3
Үндсэн хөрөнгийн хуримтлал	5.1	-4.6	0.8	0.6
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт ³	-5.0	-6.5	20.1	8.7
Цэвэр экспорт	1.4	-0.7	-9.9	-10.8
Бараа, үйлчилгээний экспорт	6.7	-11.0	-4.3	5.6
Бараа, үйлчилгээний импорт (-)	5.4	-10.3	5.6	16.4

ДНБ-ий 3.7 хувийн өсөлтийн 5.3 нэгж хувь нь эцсийн хэрэглээнд, 9.3 нэгж хувь нь хөрөнгийн нийт хуримтлалд, -10.8 нэгж хувь нь цэвэр экспортод тус тус ногдож байна.

Эцсийн хэрэглээ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2022 оны эхний 9 сард 16.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.0 (6.5%) их наяд төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 21. ӨРХИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, хувиар, өмнөх оны мөн үеэс




Өрхийн эцсийн хэрэглээ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2022 оны эхний 9 сард 13.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 918.1 (7.2%) тэрбум төгрөгөөр өсөж, ДНБ-д 4.7 нэгж хувиар эерэг нөлөө үзүүлсэн байна.

Төрийн байгууллагын хэрэглээ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2022 оны эхний 9 сард 3.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 112.9 (3.6%) тэрбум төгрөгөөр өсөж, ДНБ-д 0.6 нэгж хувиар нөлөөлжээ.

Хөрөнгийн нийт хуримтлал (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2022 оны эхний 9 сард 10.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.8 (20.1%) их наяд төгрөгөөр өссөн байна.


ЗУРАГ 22. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН НИЙТ ХУРИМТЛАЛЫН ӨСӨЛТ, БУУРАЛТ, өмнөх оны мөн үеэс, хувиар



Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2022 оны эхний 9 сард 5.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 109.5 (2.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Бараа, үйлчилгээний цэвэр экспорт (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2022 оны эхний 9 сард (-7.4) их наяд төгрөг боллоо.

ЗУРАГ 23. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭКСПОРТ, ИМПОРТЫН ХЭМЖЭЭ, их наяд төгрөгөөр



Бараа, үйлчилгээний экспорт (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2022 оны эхний 9 сард 9.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.1 (13.3%) их наяд төгрөгөөр өслөө.

Бараа, үйлчилгээний импорт 16.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.2 (23.8%) их наяд төгрөгөөр өсжээ.

Гадаад эдийн засгаас хүлээн авсан цэвэр орлого 2022 оны эхний 9 сард (-5.2) их наяд төгрөг, хоёрдогч орлого буюу цэвэр шилжүүлэг 1.2 их наяд төгрөг болж, ҮНО 30.0 их наяд төгрөг, ҮНЭО 31.1 их наяд төгрөг боллоо. ҮНО, оны үнээр өмнөх оны мөн үеэс 16.9 хувиар, ҮНЭО 16.5 хувиар тус тус өслөө.

ХҮСНЭГТ 15. ДНБ, ҮНО, ҮНЭО, оны үнээр

	2019	2020 ¹	2021 ¹	2022*	2022*
	I-X	I-X	I-X	I-X	2021 ¹
	тэрбум төгрөг				хувь
Дотоодын нийт бүтээгдэхүүн	27 617.2	26 579.2	29 925.7	35 234.0	117.7
Гадаад эдийн засгаас хүлээн авсан анхдагч орлого, цэвэр	-2 966.6	-2 150.0	-4 269.6	-5 245.8	122.9
Ажиллагчдын цалин, цэвэр	403.0	550.6	429.8	498.5	116.0
хүлээн авсан цалин (+)	600.9	658.1	581.5	634.1	109.0
төлсөн цалин (-)	197.8	107.5	151.7	135.6	89.4
Хөрөнгө оруулалтын орлого, цэвэр	-3 369.7	-2 700.7	-4 699.5	-5 744.3	122.2
Хөрөнгө оруулалтын орлого (+)	164.7	68.6	43.9	135.7	309.1
Хөрөнгө оруулалтын зардал (-)	3 534.4	2 769.3	4743.4	5 880.0	124.0
Үндэсний нийт орлого	24 650.6	24 429.1	25 656.1	29 988.2	116.9
Гадаад эдийн засгаас хүлээн авсан хоёрдогч орлого, цэвэр	518.4	611.6	1 063.2	1 152.0	108.4
Харьяат бусаас хүлээн авсан (+)	782.0	834.1	1 237.7	1 537.1	124.2
Харьяат бусад төлсөн (-)	263.6	222.5	174.5	385.1	220.7
Үндэсний нийт эзэмшлийн орлого	25 169.0	25 040.7	26 719.3	31 140.3	116.5

¹ ААНБ-ын жилийн эцсийн гүйцэтгэл, судалгаанд үндэслэсэн тооцоо

² Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.

³ Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлал, статистик зөрүү орсон.

Ойлголт, тодорхойлолт:

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд тайлант хугацаанд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн шинээр бүтээсэн нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм. ДНБ-ийг дараах 3 аргаар тооцно.

Үйлдвэрлэлийн арга: Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасаж нэмэгдэл өртгийн нийлбэр дүнгээр тооцохыг,

Эцсийн ашиглалтын арга: Эцсийн хэрэглээ, хөрөнгийн нийт хуримтлал, цэвэр экспортын (экспорт, импортын зөрүү) нийлбэрээр тооцохыг,

Орлогын арга: Ажиллагчдын цалин хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар, үйл ажиллагааны цэвэр ашиг/холимог орлого зэрэг орлогын үзүүлэлтийн нийлбэрээр тооцохыг ойлгоно.

Үндэсний нийт орлого: Тухайн улсын эдийн засгийн харьяатуудын шинээр бий болгосон нэмэгдсэн өртөг бөгөөд ҮНО-ыг тооцохдоо ДНБ-ий гүйцэтгэл дээр харьяат болон харьяат бусын хооронд хийгдсэн анхдагч цэвэр орлогын хэмжээг нэмнэ. Анхдагч орлогод а.харьяат бус ажиллагчдад төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, б.хөрөнгө оруулалтын орлого буюу харьяат, харьяат бусын хооронд харилцан шилжүүлсэн ногдол ашиг, хүүгийн орлого орно.

Үндэсний нийт эзэмшлийн орлого (ҮНЭО): Зарцуулах боломжтой орлогыг илэрхийлнэ.

ҮНЭО-ыг ҮНО болон харьяат, харьяат бусын хооронд хийгдсэн хоёрдогч орлого буюу цэвэр шилжүүлгийн нийлбэрээр тооцно. Шилжүүлэг гэдэг нь эдийн засгийн нэг сектор нөгөө сектортоо ямар нэг хариу төлбөр авахгүйгээр өгч байгаа бараа, үйлчилгээ, санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгө юм. Урсгал шилжүүлэг нь урсгал татвар, нийгмийн даатгалын шимтгэл, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, бусад урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

ДНБ-ийг улирлаар, үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаар, ҮНО, ҮНЭО-ыг улирлаар тооцож байна.





МӨНГӨ, ЗЭЭЛ, ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ, 2022 оны 10 дугаар сарын эцэст

ӨМНӨГӨЙ НИЙЛҮҮЛЭЛТ
 ЗЭЭЛ
 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ
 ТӨГРӨГИЙН ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ



**Мөнгөний
нийлүүлэлт**
их наяд төгрөг




2021 X	27.1
2022* X	27.3

* урьдчилсан гүйцэтгэл



**Зээл
2022* X**




Үнэт цаасны арилжаа **130.8** сая ширхэг **68.5** тэрбум төгрөг

Зах зээлийн үнэлгээ **5.5** их наяд төгрөг

ТОП-20 дундаж индекс **НЭГЖ 33 951.3**

Төгрөгийн валюттай харьцах
Монголбанкны нэрлэсэн ханш, сарын дундаж, төгрөг





Валютын хадгаламж 4.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 26.8 (0.6%) тэрбум төгрөгөөр өсжээ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2022 оны 10 дугаар сарын эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 27.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 183.4 (0.7%) тэрбум төгрөгөөр өсөхөд валютын харилцах 1.9 (82.2%) их наяд төгрөгөөр, валютын хадгаламж 611.4 (15.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Бага мөнгө (M1) 2022 оны 10 дугаар сарын эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 6.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 128.7 (2.1%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 358.5 (6.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Бага мөнгө (M1)-ий 5.3 (87.8%) их наяд төгрөг нь төгрөгийн харилцах, 735.6 (12.2%) тэрбум төгрөг нь хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө байна.

Бараг мөнгө 2022 оны 10 дугаар сарын эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 21.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 79.6 (0.4%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 175.2 (0.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Бараг мөнгөний 12.4 (58.5%) их наяд төгрөг нь төгрөгийн хадгаламж, 4.6 (21.9%) их наяд төгрөг нь валютын хадгаламж, 4.1 (19.6%) их наяд төгрөг нь валютын харилцах байна.


Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2022 оны 10 дугаар сарын эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 1.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 6.9 (0.7%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 81.6 (7.5%) тэрбум төгрөгөөр буурчээ.

ХҮСНЭГТ 16.МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2020 X	2021 X	2022*		2022* X	2022* X
			IX	X	2022 IX	2021 X
	тэрбум төгрөг				хувь	
Мөнгө M2	22 785.3	27 071.4	27 463.1	27 254.8	99.2	100.7
Төгрөгийн харилцах	2 955.9	4 865.8	5 448.1	5 310.5	97.5	109.1
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	687.3	821.9	726.8	735.6	101.2	89.5
Төгрөгийн хадгаламж	12 226.7	15 072.2	12 566.8	12 414.0	98.8	82.4
Валютын хадгаламж	4 925.0	4 034.9	4 619.5	4 646.3	100.6	115.2
Валютын харилцах	1 990.4	2 276.7	4 101.9	4 148.3	101.1	182.2
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	959.8	1 087.4	999.0	1 005.9	100.7	92.5


Гадаад цэвэр актив 2022 оны 10 дугаар сарын эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 113.9 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 676.4 (85.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 4.2 (97.4%) их наяд төгрөгөөр буурсан бол дотоод цэвэр актив 27.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 468.1 (1.8%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 4.4 (19.5%) их наяд төгрөгөөр өсжээ. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийг дотоод цэвэр актив бүрдүүлсэн байна.

ЗУРАГ 24. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ, байршуулалт талаас, сараар




Төгрөгийн хадгаламж 2022 оны 10 дугаар сарын эцэст 12.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 152.8 (1.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 2.7 (17.6%) их наяд төгрөгөөр буурчээ. Төгрөгийн хадгаламжийн 11.2 (90.3%) их наяд төгрөг нь иргэдийн хадгаламж, 1.2 (9.7%) их наяд төгрөг нь аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж байна. Валютын хадгаламж 4.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 26.8 (0.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 611.4 (15.2%) тэрбум төгрөгөөр өсжээ.

ЗУРАГ 25. ИРГЭД, БАЙГУУЛЛАГЫН ХАДГАЛАМЖ, ТӨГРӨГИЙН ХАДГАЛАМЖ, сараар




ЗУРАГ 26. ТӨГРӨГ, ВАЛЮТЫН ХАДГАЛАМЖ, НИЙТ ХАДГАЛАМЖ сараар



Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны 10 дугаар сарын эцэст 22.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 174.1 (0.8%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.7 (13.6%) их наяд төгрөгөөр өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 52.0 хувь нь иргэдийнх, 46.6 хувь нь хувийн байгууллагынх, 0.8 хувь нь санхүүгийн болон бусад байгууллагынх, 0.6 хувь нь төрийн байгууллагынх байна.

ЗУРАГ 27. ИРГЭД, ХУВИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, НИЙТ ЗЭЭЛИЙН ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ, хувиар, сараар



Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны 10 дугаар сарын эцэст 18.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 329.8 (1.7%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 1.9 (10.9%) их наяд төгрөгөөр өсжээ. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 83.0 хувийг эзэлж байна.


ХҮСНЭГТ 17. АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, зээлийн ангиллаар, сарын эцэст

Үзүүлэлт	2020 X	2021 X	2022*		2022* X	2022* X
			IX	X	2021 X	2022* IX
			тэрбум төгрөг			
Зээлийн өрийн үлдэгдэл	17 215.5	20 085.0	22 984.7	22 810.6	113.6	99.2
Хэвийн зээл	13 985.1	17 072.4	19 255.0	18 925.2	110.9	98.3
Хугацаа хэтэрсэн зээл	1 226.3	1 035.9	1 164.8	1 227.8	118.5	105.4
Чанаргүй зээл	2 004.1	1 976.7	2 564.8	2 657.5	134.4	103.6

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны 10 дугаар сарын эцэст 1.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 63.0 (5.4%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 191.9 (18.5%) тэрбум төгрөгөөр өсжээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.4 хувийг эзэлж байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2022 оны 10 дугаар сарын эцэст 2.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 92.7 (3.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 680.9 (34.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.7 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 28. ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ, сар бүрийн эцэст, тэрбум төгрөг



Арилжааны банкууд болон Монголын Ипотекийн корпорац (МИК)-аас иргэдэд олгосон ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны 9 дүгээр сарын эцэст 6.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 78.0 (1.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 738.0 (13.5%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.

ХҮСНЭГТ 18. ИРГЭДЭД ОЛГОСОН ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, сарын эцэст

	2021 IX	2022*		2022* IX	2022* IX
		VIII	IX	2021 IX	2022 VIII
				хувь	
Иргэдэд олгосон ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр	5452.5	6112.5	6190.5	113.5	101.3
Иргэдэд олгосон ипотекийн зээлийн дансны тоо, мянган ширхэг	103.3	106.3	106.8	103.4	100.5

Үнэт цаасны арилжаагаар 2022 оны эхний 10 сард 367.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 439.4 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеэс гүйлгээ 739.6 (66.8%) тэрбум төгрөгөөр, арилжсан үнэт цаас 101.6 (18.8%) сая ширхгээр буурчээ.


Үнэт цаасны гүйлгээ 2022 оны 10 дугаар сард 68.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 50.5 (3.8 дахин) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 54.2 (4.8 дахин) тэрбум төгрөгөөр өсжээ. Арилжсан үнэт цаас 130.8 сая ширхэг болж, өмнөх сараас 93.1 (2.5 дахин) сая ширхгээр, өмнөх оны мөн үеэс 113.3 (7.5 дахин) сая ширхгээр өссөн байна.

ЗУРАГ 29. ҮНЭТ ЦААСНЫ ГҮЙЛГЭЭ, АРИЛЖСАН ҮНЭТ ЦААС, сараар



Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2022 оны 10 дугаар сард 33951.3 нэгж болж, өмнөх сараас 651.2 нэгжээр, өмнөх оны мөн үеэс 6406.2 нэгжээр буурсан байна.

ЗУРАГ 30. ТОП-20 ДУНДАЖ ИНДЕКС, сараар



Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2022 оны 10 дугаар сард 5.5 их наяд төгрөг болж, өмнөх сараас 669.2 (14.0%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 588.3 (12.1%) тэрбум төгрөгөөр өсжээ.

ЗУРАГ 31. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, сараар



Монголбанкнаас зарласан төгрөгийн америк доллартой харьцах сарын дундаж ханш 2022 оны 10 дугаар сард 3369.90 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 520.93 төгрөгөөр, өмнөх сараас 112.79 төгрөгөөр суларсан байна.


Монголбанкнаас зарласан төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2022 оны 10 дугаар сард 468.39 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 24.68 төгрөгөөр, өмнөх сараас 4.50 төгрөгөөр суларсан байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш 2022 оны 10 дугаар сард 54.77 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 14.86 төгрөгөөр, өмнөх сараас 0.29 төгрөгөөр суларсан байна.

ХҮСНЭГТ 19МОНГОЛБАНКНААС ЗАРЛАСАН ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ САРЫН ДУНДАЖ ХАНШ, төгрөгөөр

Үзүүлэлт	2019 X	2020 X	2021 X	2022 X
Америк доллар	2 678.01	2 853.60	2 848.97	3 369.90
Евро	2 958.16	3 359.46	3 305.51	3 315.59
Рубль	41.62	36.77	39.91	54.77
Юань	377.38	424.25	443.71	468.39

ЗУРАГ 32. ТӨГРӨГИЙН АМЕРИК ДОЛЛАРТой ХАРЬЦАХ ХАНШИЙН ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ, хувиар, сараар



Ойлголт, тодорхойлолт

Бага мөнгө /M1/: Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Мөнгөний нийлүүлэлт /M2/: Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно. Өөрөөр хэлбэл, бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно. Зөвхөн цэвэршүүлсэн алтны харилцах дансны үлдэгдлийг хамруулах бөгөөд бусад үнэт металлын харилцах дансны үлдэгдлийг хамруулахгүй.

Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө: Төв банкнаас гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгөнөөс банкнуудын эзэмшиж буй цаасан болон зоосон мөнгийг хасна.

Бараг мөнгө: Төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Валютын харилцах: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тодорхойлно.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө: Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон банкны касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Төгрөг болон валютын хадгаламж: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тодорхойлно.

Үнэт цаас: Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компанийн бүх төрлийн хувьцаа, компанийн гаргасан, эсвэл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн бичиг (опцион), хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос "Үнэт цаасны зах зээлийн тухай" Монгол Улсын хуульд нийцүүлэн үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг ойлгоно.

Хувьцаа: Компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг ойлгоно.

Брокерын үйл ажиллагаа: Үнэт цаасны зах зээлд бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авах ажиллагааг ойлгоно.

Дилерийн үйл ажиллагаа: Үнэт цаасны зах зээлд ашиг олох зорилгоор үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авах, худалдах, арилжих ажиллагааг ойлгоно.

Бүртгэлтэй компани: Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй, хувьцааны арилжааг идэвхтэй хийдэг хувьцаат компанийг тоог хамруулна.

Хэлцэл: Үнэт цаасыг худалдах захиалгын үнийн саналыг худалдан авах иргэд, аж ахуйн нэгж, байгууллага зөвшөөрснөөр үнэт цаас арилжаалахыг ойлгоно.

Зах зээлийн үнэлгээ: Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн нийтэд гаргасан үнэт цаасны тоо, тухайн өдрийн үнэт цаасны арилжааны хаалтын ханшны үржвэрээр тодорхойлно.

Өрийн бичиг (бонд): Тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн, эсвэл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаасыг ойлгоно.

ТОП 20 индекс: Үнэт цаасны үнийн ерөнхий өөрчлөлтийг илэрхийлэх бөгөөд Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, үнэт цаасны өсөлт, бууралтаар үнэт цаасны зах зээлийн ерөнхий чиг хандлагыг тодорхойлно.

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Тооцох аргачлал:

ТОП 20 индексийг дараах томъёогоор тооцно.

$$I = \frac{P}{C} * 100$$

I - Тухайн өдрийн индекс

P - Тухайн өдрийн зах зээлийн үнэлгээ


C - Зах зээлийн суурь үнэлгээ






УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 10 сард, тэрбум төгрөг


ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠨᠡᠭᠳᠦᠰᠡᠨ ᠲᠦᠰᠦᠢᠨ ᠣᠷᠯᠣᠭ᠎ᠠ, ᠵᠠᠷᠯᠠᠭ᠎ᠠ



Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын бүтэц



- Татварын орлого
- Татварын бус орлого
- Тогтворжуулалтын сангийн орлого




- Урсгал зардал
- Хөрөнгийн зардал
- Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 15.3 хувиар өсжээ

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2022 оны эхний 10 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 14.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (15.3%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 13.0 их наяд төгрөг болж, 2.3 (21.7%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 33. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО, ЗАРЛАГА, ТЭНЦЭЛ, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, тэрбум төгрөг



Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2022 оны эхний 10 сард 14.0 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.0 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, төсвийн алдагдал өмнөх оны мөн үеэс 529.2 (34.2%) тэрбум төгрөгөөр буурчээ.


Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ 2022 оны 10 дугаар сард 1.5 их наяд төгрөг болж, өмнөх сараас 30.8 (2.1%) тэрбум төгрөгөөр, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 1.5 их наяд төгрөг болж, 36.4 (2.4%) тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

Татварын нийт орлого 2022 оны эхний 10 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 12.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.6 (27.3%) их наяд төгрөгөөр өсөхөд нэмэгдсэн өртгийн албан татвар 852.9 (37.3%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 635.8 (36.7%) тэрбум төгрөг, бусад төрлийн татварын орлого 912.5 (95.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин орлогын албан татварын орлого 157.3 (5.3%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Татварын нийт орлого 2022 оны 10 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 403.4 (44.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татварын орлого 89.7 (30.4%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 97.8 (48.1%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 57.7 (29.7%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын нийт орлогод 2022 оны эхний 10 сарын байдлаар бусад татвар, төлбөр, хураамжийн орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 5.5 нэгж хувь, нэмэгдсэн өртгийн албан татварынх 1.9 нэгж хувь, нийгмийн даатгалын орлогынх 1.4 нэгж хувь, гадаад үйл ажиллагааны орлогынх 0.6 нэгж хувиар тус тус өсөж, харин орлогын албан татварынх 8.1 нэгж хувь, онцгой албан татварын орлогынх 1.3 нэгж хувиар тус тус буурсан байна.


ЗУРАГ 34. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТАТВАРЫН ОРЛОГЫН БҮТЭЦ, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар



Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2022 оны эхний 10 сард 14.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.8 (14.6%) их наяд төгрөгөөр өссөн байна. Зарлагын өсөлтөд урсгал шилжүүлгийн зардал өмнөх оны мөн үеэс 1.4 (24.1%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин бараа, үйлчилгээний зардал 521.2 (15.4%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Урсгал зардалд урсгал шилжүүлгийн эзлэх хувь 2022 оны эхний 10 сард өмнөх оны мөн үеэс 7.1 нэгж хувь, татаас 0.6 нэгж хувиар өсөж, харин бараа үйлчилгээний зардлынх 7.6 нэгж хувь, хүүгийн зардал 0.1 нэгж хувиар буурсан байна.

ЗУРАГ 35. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫН БҮТЭЦ, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар



Хөрөнгийн зардал 2022 оны эхний 10 сард 2.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 680.3 (38.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хөрөнгийн зардалд барилга байгууламжийн зардлын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 13.4 нэгж хувь, их засварын зардлынх 0.2 нэгж хувиар өсөж, бусад хөрөнгийн зардлынх 6.9 нэгж хувь, тоног төхөөрөмжийн зардлынх 5.4 нэгж хувь, стратегийн нөөц хөрөнгийн зардлынх 0.3 нэгж хувиар тус тус буурчээ.

Даатгалын сан

Нийгмийн даатгалын сангийн орлого 2022 оны эхний 10 сард 2.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 701.5 (32.8%) тэрбум төгрөг, нийт зарлага 2.8 их наяд төгрөг болж, 708.3 (33.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 20. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	2019	2020	2021	2022*	<u>2022* I-X</u>
	I-X	I-X	I-X	I-X	<u>2021 I-X</u>
	тэрбум төгрөг				хувь
Нийт орлого	1 962.6	1 575.0	2 137.2	2 838.6	132.8
Нийгмийн даатгалын сангийн орлого	1 458.0	1 201.5	1 623.3	2 090.0	128.8
Тусламжийн орлого	504.6	373.5	513.9	748.6	145.7
Нийт зарлага	1 705.8	2 035.7	2 088.9	2 797.2	133.9
Бараа үйлчилгээний зардал	18.6	20.2	20.0	21.0	105.1
Урсгал шилжүүлэг	1 687.2	2 015.5	2 098.1	2 780.6	132.5
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	-	-	- 29.2	- 4.5	15.4
Тэнцэл	256.7	- 460.7	48.3	41.4	-

¹ Дахин их

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2022 оны эхний 10 сард 1.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 264.7 (32.6 хувь) тэрбум төгрөг, нийт зарлага 1.4 их наяд төгрөг болж, 382.3 (36.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт зардал өсөхөд Засгийн газрын урсгал шилжүүлгийн зардал өмнөх оны мөн үеэс 347.0 (36.1%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 21. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	2019 I-X	2020 I-X	2021 I-X	2022* I-X	<u>2022* I-X</u>
					<u>2021 I-X</u>
	тэрбум төгрөг				хувь
Нийт орлого	378.9	357.5	811.1	1 075.7	132.6
ЭМД-ын хураамжийн шимтгэл	378.9	357.5	811.1	1 075.7	132.6
Нийт зарлага	267.4	327.6	1 035.9	1 418.3	136.9
Бараа үйлчилгээний зардал	3.1	2.9	28.0	50.9	181.8
Татаас	29.4	31.8	52.2	64.0	122.5
Урсгал шилжүүлэг	234.9	292.9	962.5	1309.4	136.1
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	-	-	-6.7	-6.1	90.1
Тэнцэл	111.4	29.9	-224.9	-342.5	152.3

¹ Дахин их

Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, хүний хөгжил сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.





ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, 2022 оны эхний 9 сарын байдлаар , сая америк доллар

АУГУУС
ТҮ
АМГУУЛ

Урсгал дансны тэнцэл

Алдагдалтай **\$ -2 452.3**



\$ 62.2

Бараа



\$ -1 428.3

Үйлчилгээ



\$ -1 467.6

Анхдагч орлого



\$ 381.4

Хоёрдогч орлого

Санхүүгийн дансны тэнцэл

Ашигтай **\$ -1 236.8**



\$ -1 370.5

Шууд хөрөнгө оруулалт



\$ -23.3

Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд



\$ 116.1

Багцын хөрөнгө оруулалт



\$ 40.9

Бусад хөрөнгө оруулалт



\$ -249.9

Алдаа ба орхигдуулга



\$ -1 358.9


Нөөц хөрөнгө



Төлбөрийн тэнцэл 2022 оны эхний 9 сарын байдлаар 1.4 тэрбум америк долларын алдагдалтай гарлаа

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2022 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 2.5 тэрбум америк долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 545.2 (28.6%) тэрбум америк доллароор өсжээ. Уг өсөлтөд барааны худалдааны алдагдал өмнөх оны мөн үеэс 380.2 сая америк доллароор, үйлчилгээний худалдааны алдагдал 204.1 сая америк доллароор өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин урсгал дансны алдагдал 2022 оны 9 дүгээр сард өмнөх сараас 183.2 сая америк доллароор буурч, 34.1 сая америк доллар болжээ.

ЗУРАГ 36. УРСГАЛ ДАНС, сая америк доллароор, сараар



Үйлчилгээний худалдааны орлого 2022 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 803.5 сая америк доллар, зарлага 2.2 тэрбум америк доллар болж, орлого өмнөх оны мөн үеэс 253.6 сая америк доллароор, зарлага 457.8 сая америк доллароор тус тус өссөн байна. Үйлчилгээний худалдааны алдагдал 2022 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 204.1 сая америк доллароор өсөж, 1.4 тэрбум америк доллар болжээ.

ХҮСНЭГТ 22. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, салбараар, сая америк доллароор

Үзүүлэлт	2021		2022*	
	IX	ИХ	IX	ИХ
Үйлчилгээ	- 237.4	-1 224.1	- 305.8	-1 428.3
Кредит	71.6	549.8	132.3	803.5
Дебит	309.0	1 774.0	438.1	2 231.7
Тээвэр	-10.7	-132.7	-65.5	-406.9
Кредит	49.3	379.3	57.1	425.3
Дебит	60.1	511.9	122.5	832.2
Аялал	-141.6	-601.1	-137.7	-521.9
Кредит	2.4	14.4	38.5	171.1
Дебит	144.0	615.4	176.2	693.0
Бусад үйлчилгээ	-85.0	-490.4	-102.6	-499.4
Кредит	19.9	156.2	36.7	207.0
Дебит	104.9	646.6	139.4	706.4

Хөрөнгийн данс 2022 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 106.4 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 19.4 сая америк доллароор өсжээ. Мөн 2022 оны 9 дүгээр сард 24.7 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 58.0 сая америк доллароор өссөн байна.

Санхүүгийн дансны тэнцэл 2022 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.2 тэрбум америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 236.1 сая америк доллароор өсжээ. Харин 2022 оны 9 дүгээр сард 189.3 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 299.7 сая америк доллароор буурсан байна.

ХҮСНЭГТ 23.ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД,
сая америк доллароор

Үзүүлэлт	2021		2022*	
	IX	ИХ	IX	ИХ
Урсгал данс	- 213.7	-1 907.0	- 34.1	-2 452.3
Хөрөнгийн данс	22.0	87.0	24.7	106.4
Санхүүгийн данс	0.9	-1 000.8	-189.3	-1 236.8
Алдаа болон орхигдуулга	23.5	239.0	-16.8	-249.9
Нөөц хөрөнгө	-169.0	-580.3	163.1	-1 358.9

Төлбөрийн тэнцэл 2022 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.4 тэрбум америк долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 778.7 сая америк доллароор өссөн байна. Харин 2022 оны 9 дүгээр сард 163.1 сая америк долларын ашигтай гарч, ашиг өмнөх сараас 368.3 сая америк доллароор өсжээ.

Ойлголт, тодорхойлолт

Төлбөрийн тэнцэл: Тодорхой хугацаанд эдийн засгийн харьяат болон эдийн засгийн харьяат бусын хооронд хийсэн худалдаа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлэг, санхүүгийн болон хөрөнгийн урсгалыг системчлэн нэгтгэсэн статистикийн тайлан юм.

Урсгал данс: Эдийн засгийн харьяат болон харьяат бусын хоорондох бараа, үйлчилгээ, анхдагч орлого, орлогын дахин хуваарилалтын урсгалыг харуулах бөгөөд бараа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлгийн нийлбэрээс бүрдэнэ.

Хөрөнгийн данс: Хөрөнгийн шилжүүлэг болон үйлдвэрлэгддэггүй, санхүүгийн бус активын шилжүүлэг гэсэн хоёр ангиллаар бүртгэнэ.

Санхүүгийн данс: Монгол Улсаас бусад гадаад улсад хийсэн хөрөнгө оруулалт/актив/, бусад улсаас Монгол Улсад хийсэн хөрөнгө оруулалтын/пассив/ гүйлгээг бүртгэдэг бүх данс хамаарна. Санхүүгийн дансанд активын өсөлт пассивынхаас илүү, активын бууралт пассивынхаас бага эсвэл актив өсөж, пассив буурсан үед "+" буюу алдагдалтайг, эсрэгээр пассивын өсөлт активынхаас илүү, активын бууралт пассивынхаас илүү эсвэл актив буурч, пассив өссөн үед "-" буюу ашигтайг илэрхийлнэ.


Цэвэр нөөц: Гадаад валютын улсын нөөцийг Олон Улсын Валютын Сангийн зээлийн үлдэгдэл болон богино хугацаат гадаад пассивын дүнгээр цэвэрлэж тооцсон нөөцийг ойлгоно. Цэвэр нөөцийг Монголбанкнаас гаргасан гадаад валютын цэвэр нөөцийн тайланд үндэслэн тооцдог. **Шууд хөрөнгө оруулалт:** Харьяат бус нь нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагааны удирдлагад нөлөөлөхүйц саналын эрх бүхий хэмжээний хөрөнгийг харьяат аж ахуйн нэгжид нийлүүлэх, салбар, харьяа нэгжийг байгуулах үйл ажиллагааг ойлгоно.





ГАДААД ХУДАЛДАА, 2022 оны эхний 10 сард

ТҮНШ УЛСУУД



ГОЛ ТҮНШ УЛСУУД, сая америк доллар, хувиар

Улс	Хэмжээ (сая америк доллар)	Хувий
БНХАУ	8 449.7	84.9%
Швейцар	768.6	7.7%
Сингапур	324.7	3.2%
БНСУ	167.9	1.7%
Итали	74.5	0.7%
Бусад	173.4	1.7%


Улс	Хэмжээ (сая америк доллар)	Хувий
БНХАУ	2 504.3	35.0%
ОХУ	2 162.8	30.3%
ЯПОН	576.5	8.1%
БНСУ	356.3	5.0%
АНУ	212.6	3.0%
ХБНГУ	148.3	2.1%
Бусад	1 184.6	16.6%



Экспорт өмнөх сараас 6.4 хувиар буурлаа

Монгол Улс 2022 оны эхний 10 сард нийт 157 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 17.2 тэрбум америк доллар, үүнээс экспорт 10.0 тэрбум америк доллар, импорт 7.1 тэрбум америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.0 (30.3%) тэрбум америк доллароор, экспорт 2.5 (33.0%) тэрбум америк доллароор, импорт 1.5 (26.6%) тэрбум америк доллароор тус тус өсжээ. Харин 2022 оны 10 дугаар сард экспорт өмнөх сараас 74.4 (6.4%) сая америк доллароор буурсан бол импорт 32.4 (4.3%) сая америк доллароор өссөн байна.

ЗУРАГ 37. ЭКСПОРТ, ИМПОРТ, ТЭНЦЭЛ, сараар, сая америк доллароор



Гадаад худалдааны тэнцэл 2022 оны эхний 10 сард 2.9 тэрбум америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 1.0 (52.4%) тэрбум америк доллароор өсжээ. Харин 2022 оны 10 дугаар сард 300.0 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 106.8 (26.3%) сая америк доллароор буурсан байна.

БНХАУ-тай 2022 оны эхний 10 сард 11.0 тэрбум америк долларын худалдааг хийжээ. Энэ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 64.1 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 24. ЭКСПОРТ, гол түнш улсаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Улс орон	2020 I-X		2021 I-X		2022* I-X	
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь
Дүн	5 986.1	100.0	7 523.5	100.0	10 008.8	100.0
БНХАУ	4 418.8	73.8	6 496.5	86.3	8 499.7	84.9
Швейцар	1 216.0	20.3	502.3	6.7	768.6	7.7
Сингапур	131.8	2.2	137.4	1.8	324.7	3.2
БНСУ	17.8	0.3	181.4	2.4	167.9	1.7
Итали	16.8	0.3	25.8	0.3	74.5	0.7
Бусад	184.8	3.1	180.1	2.4	173.4	1.7

БНХАУ-д экспортолсон бараа бүтээгдэхүүний 55.3 хувийг чулуун нүүрс, 27.6 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол Швейцар улсад экспортолсон барааны 99.7 хувийг алт эзэлж байна.

Экспорт 2022 оны эхний 10 сард өмнөх оны мөн үеэс 2.5 тэрбум америк доллароор өсөхөд нүүрсний экспорт 3.1 тэрбум америк доллароор, алтны экспорт 189.2 сая америк доллароор өссөн нь голлон нөлөөлжээ.


ХҮСНЭГТ 25. УУЛ УУРХАЙН ГАРАЛТАЙ ЭКСПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН, жил бүрийн эхний 10 сарын байдлаар


Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		2022* I-X 2021 I-X	Үнийн дүн		2022* I-X 2021 I-X хувь
		2021 I-X	2022* I-X		2021 I-X	2022* I-X	
		сая ам.доллар					
Зэсийн баяжмал	мян.тн	1 158.8	1 200.5	103.6	2 624.3	2 342.8	89.3
Нүүрс	сая тн	13.9	23.1	166.7	1 987.5	5 115.4	2.6 ¹
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	тн	10.8	14.1	130.6	628.0	817.2	130.1
Төмрийн хүдэр, баяжмал	мян.тн	6 557.7	3 876.3	59.1	906.3	337.0	37.2
Боловсруулаагүй газрын тос	мян.бар	4 036.4	1 726.2	42.8	249.7	170.1	68.1

¹ Дахин их

Зэсийн баяжмалын хилийн дундаж үнэ 2022 оны 10 дугаар сард өмнөх сараас тонн тутамд 4.3 америк доллароор, боловсруулаагүй газрын тос хилийн дундаж үнэ баррель тутамд 2.6 америк доллароор тус тус өсжээ.


ЗУРАГ 38. ЭКСПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, ам.доллароор, сараар





Нүүрсний экспортын биет хэмжээ 2022 оны 10 дугаар сард 4.1 сая тонн болж, өмнөх сараас 69.3 мянган тонноор, үнийн дүн 608.3 сая америк доллар болж, 15.1 сая америк доллароор тус тус буурчээ.

ЗУРАГ 39. НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН, сараар



Импортын дүнд 2022 оны эхний 10 сарын байдлаар БНХАУ 35.0%, ОХУ 30.3%, Япон 8.1%, БНСУ 5.0%, АНУ 3.0%, ХБНГУ 2.1 хувийг тус тус эзэлж, нийт импортын 83.4 хувийг бүрдүүлж байна.

ХҮСНЭГТ 26. ИМПОРТ, гол түнш улсаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Улс	2020 I-X		2021 I-X		2022* I-X	
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь
Дүн	4 437.0	100.0	5 645.2	100.0	7 145.6	100.0
БНХАУ	1 634.1	36.8	2 243.7	39.7	2 504.3	35.0
ОХУ	1 146.0	25.8	1 494.1	26.5	2 162.8	30.3
Япон	344.6	7.8	359.2	6.4	576.5	8.1
БНСУ	196.5	4.4	243.2	4.3	356.3	5.0
Америк	209.2	4.7	177.4	3.1	212.6	3.0
Герман	148.6	3.3	189.7	3.4	148.3	2.1
Бусад	758.0	17.1	937.7	16.6	1 184.6	16.6

ОХУ-аас импортолсон барааны 59.5 хувийг нефтийн бүтээгдэхүүн, Япон Улсаас импортолсон барааны 66.7 хувийг суудлын автомашин, БНХАУ-аас импортолсон барааны 4.5 хувийг цахилгаан эрчим хүч, 9.1 хувийг ачааны автомашин эзэлж байна.

Импорт өмнөх оны мөн үеэс 1.5 тэрбум америк доллароор өсөхөд дизелийн түлшний импорт 307.2 сая америк доллар, автобензиний импорт 197.2 сая америк доллар, суудлын автомашины импорт 177.3 сая америк доллароор тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 27.ИМПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		2022* I-X	Үнийн дүн		2022* I-X
		2021 I-X	2022* I-X	2021 I-X	2021 I-X	2022* I-X	2021 I-X
		сая ам.доллар					
Дизелийн түлш	мян.тн	803.3	784.3	97.6	449.7	756.8	168.3
Автобензин	мян.тн	411.2	549.1	133.5	261.2	458.4	175.5
Суудлын автомашин	мян.ш	45.1	56.9	126.4	304.2	481.6	158.3
Ачааны автомашин	мян.ш	23.0	20.0	86.8	361.6	326.4	90.3
Цахилгаан эрчим хүч	сая квт.ц	1 454.2	1 741.3	119.7	128.5	151.3	117.8

Эрдэс бүтээгдэхүүн, үнэт чулуу, металл, гоёлын зүйлс болон нэхмэл бүтээгдэхүүний экспорт нийт экспортын 97.8 хувийг эзэлж байгаа бол импортын 74.1 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн болон хүнсний бэлэн бүтээгдэхүүн эзэлж байна.

ХҮСНЭГТ 28. ЭКСПОРТ, ИМПОРТ, зарим барааны бүлгээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	2020 I-X	2021 I-X	2022* I-X	2022* I-X
	сая ам.доллар			хувь
Экспорт	5 986.1	7 523.5	10 008.8	133.0
Эрдэс бүтээгдэхүүн	4 228.0	6 309.0	8 519.2	135.0
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	48.6	46.5	4.7	10.1
Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	5.9	88.6	31.3	35.4
Нэхмэл бүтээгдэхүүн	254.3	274.5	450.7	164.2
Үнэт чулуу, металл, гоёлын зүйлс	1 324.4	632.9	823.6	130.1
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	1 322.2	628.0	817.2	130.1
Импорт	4 437.0	5 645.2	7 145.6	126.6
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	356.2	488.4	658.5	134.8
Эрдэс бүтээгдэхүүн	807.6	991.8	1 580.8	159.4
Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн зүйлс	478.6	512.8	696.0	135.7
Тээврийн хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги	735.4	1 065.5	1 305.5	122.5
Хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн	304.3	472.8	518.9	109.8
Хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл	191.0	211.9	289.9	136.8
Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл	904.8	1 050.9	1 056.5	100.5

Ойлголт, тодорхойлолт:

Гадаад худалдааны барааны нийт эргэлт: Экспорт, импортын нийлбэрээр тодорхойлно.

Гадаад худалдааны тэнцэл: Нийт экспортоос импортыг хассан зөрүүгээр тэнцлийг тодорхойлно. Тэнцэл (-) тэмдэгтэй бол алдагдалтай, (+) тэмдэгтэй бол ашигтай гэж үзнэ.

Импорт: Улсын материаллаг нөөцийг нэмэгдүүлэн, хилийн чанадаас эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж байгаа барааг тооцно. Нийт импортод гадаадын барааны шууд импорт, дотоодын барааны реимпорт багтана.

Экспорт: Улсын материаллаг нөөцийг хорогдуулан, эдийн засгийн нутаг дэвсгэрээс хилийн чанадад гаргаж байгаа барааг тооцно. Нийт экспортод дотоодын барааны шууд экспорт, гадаадын барааны реэкспорт багтана.

Реимпорт: Өмнө нь экспортод бүртгэгдсэн дотоодын барааны импортыг ойлгоно.

Реэкспорт: Өмнө нь импортод бүртгэгдсэн гадаадын барааны экспортыг ойлгоно.


Эх орны үйлдвэрлэлийн бараа: Тухайн улс оронд импортоор оруулж, дахин боловсруулалт хийсэн, үндсэн чанар буюу техникийн шинжийг өөрчилсөн гадаад гаралтай барааг оруулна.





ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН УЛСЫН ИНДЕКС, бүлгээр, хувиар, 2022 оны 10 дугаар сард

ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠡᠨᠢᠢ ᠶᠨᠢᠶᠢᠨ ᠤᠯᠤᠰᠤᠨ ᠢᠨᠳᠡᠬᠤ






Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.3 хувиар өслөө

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 10 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 14.5 хувь, өмнөх оны эцсээс 10.9 хувиар, өмнөх сараас 1.3 хувиар өссөн байна.

ЗУРАГ 40. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 16.4 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 24.9 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 18.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 17.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 20.6 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 9.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 10 дугаар сард өмнөх оны эцсээс 10.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 11.1 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 6.6 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 15.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 14.3 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 16.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 10 дугаар сард өмнөх сараас 1.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.1 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 1.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 1.8 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 0.4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 29. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2022 оны 10 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	<u>2022 X</u> 2021 X	<u>2022 X</u> 2021 XII	<u>2022 X</u> 2022 IX
Ерөнхий индекс	100.0	114.5	110.9	101.3
Хүнсний бараа, ундаа, ус	25.1	116.4	111.1	102.1
Согтууруулах ундаа, тамхи	1.2	108.2	106.6	101.0
Хувцас, бөс бараа, гутал	12.3	118.4	115.3	101.8
Орон сууц, ус, цахилгаан, түлш	10.3	117.2	114.3	101.1
Гэр ахуйн тавилга, бараа	5.4	115.8	112.7	101.4
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	7.3	120.6	116.9	100.7
Тээвэр	16.3	109.3	105.6	100.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	5.9	101.9	101.7	100.4
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	1.9	109.6	108.3	100.8
Боловсролын үйлчилгээ	5.2	106.7	106.7	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.9	118.6	113.8	101.2
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	0.5	103.7	103.7	100.0
Бусад бараа, үйлчилгээ	5.7	120.1	115.8	101.9

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 10 дугаар сард 10.4 хувь гарсан бол 2022 оны 10 дугаар сард 14.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 4.1 нэгж хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 30. ИНФЛЯЦАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГҮҮДИЙН ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, нэгжээр, жил бүрийн 10 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	2021 X	2022 X	Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 10 дугаар сард улсын хэмжээнд 14.5 хувь гарсны 4.3 (29.9%) нэгж хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.
Ерөнхий индекс	10.4	14.5	
Хүнсний бараа, ундаа, ус	4.7	4.3	
Согтууруулах ундаа, тамхи	0.0	0.1	
Хувцас, бөс бараа, гутал	0.4	2.2	
Орон сууц, ус, цахилгаан, түлш	0.3	1.7	
Гэр ахуйн тавилга, бараа	0.3	0.8	
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.5	1.5	
Тээвэр	3.1	1.6	
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.1	0.1	
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.1	0.2	
Боловсролын үйлчилгээ	0.2	0.3	
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	0.3	0.5	
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	0.0	0.0	
Бусад бараа, үйлчилгээ	0.4	1.1	


ХҮСНЭГТ 31. ИНФЛЯЦАД ИМПОРТЫН БАРААНЫ ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, жил бүрийн 10 дугаар сард, нэгж хувиар

Үзүүлэлт	2021 X		2022 X	
	Нэгж хувь	Хувь	Нэгж хувь	Хувь
Ерөнхий индекс	10.4	100.0	14.5	100.0
Импортын барааны нөлөө	5.7	54.8	7.6	52.6

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 410 нэр төрлийн бараа, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 404 нэр төрлийн бараа, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 410 нэр төрлийн бараа, үйлчилгээний 221 нь импортын бараа байгаа бөгөөд энэ нь нийт жингийн 46.0 хувийг эзэлж байна.

Инфляц 2022 оны 10 дугаар сард 14.5 нэгж хувь гарсны 7.6 (52.6%) нэгж хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

ЗУРАГ 41. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) сараар, хувиар




Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2021 оны 10 дугаар сард 18.6 хувиар, 2022 оны 10 дугаар сард 16.1 хувиар өсөж, өсөлтийн хурдац 2.5 нэгж хувиар буурч, харин хүнсний бус бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2021 оны 10 дугаар сард 7.6 хувиар, 2022 оны 10 дугаар сард 13.8 хувиар өсөж, өсөлтийн хурдац 6.2 нэгж хувиар нэмэгджээ.

ХҮСНЭГТ 32. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 10 дугаар сард (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), бүлгээр, хувь

Огноо	Хүнс, хүнсний бус	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	Ерөнхий индекс	110.4	109.5	112.2	111.1	112.6	111.1
2021 X	Хүнс	118.6	119.6	116.8	117.3	117.2	117.0
	Хүнсний бус	107.6	106.3	110.7	108.9	110.6	108.7
	Ерөнхий индекс	114.5	114.6	113.1	114.0	115.0	114.7
2022 X	Хүнс	116.1	115.3	114.3	119.6	116.1	117.6
	Хүнсний бус	113.8	114.4	112.5	111.9	114.5	113.6

Хүнсний бүлгийн үнэ 2022 оны 10 дугаар сард Хангайн бүсэд өмнөх оны мөн үеэс 19.6 хувь, хүнсний бус бүлгийн үнэ Төвийн бүсэд 14.5 хувиар тус тус өссөн нь хамгийн их байна.

ЗУРАГ 42. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 10 дугаар сард (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувиар




Барааны бүлгийн үнэ 2021 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 12.5 хувиар, 2022 оны 10 дугаар сард 16.5 хувиар өсөж, өсөлтийн хурдац 4.0 нэгж хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ 2021 оны 10 дугаар сард 4.7 хувиар, 2022 оны 10 дугаар сард 8.3 хувиар өсөж, өсөлтийн хурдац 3.6 нэгж хувиар тус тус нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 33. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, жил бүрийн 10 дугаар сард (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувь, бүсээр

Огноо	Бараа, үйлчилгээ	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
2021 X	Ерөнхий индекс	110.4	109.5	112.2	111.1	112.6	111.1
	Бараа	112.5	111.5	114.2	113.0	114.8	113.2
	Үйлчилгээ	104.7	104.5	105.7	105.0	105.4	103.7
2022 X	Ерөнхий индекс	114.5	114.6	113.1	114.0	115.0	114.7
	Бараа	116.5	116.5	114.8	116.5	117.9	116.9
	Үйлчилгээ	108.3	109.8	106.5	104.9	105.0	106.7

Төвийн бүсэд барааны бүлгийн үнэ 2022 оны 10 дугаар сард 17.9 хувь, Улаанбаатар хотод үйлчилгээний бүлгийн үнэ 9.8 хувиар тус тус өссөн нь хамгийн их байна.

ЗУРАГ 43. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2022 оны 10 дугаар сард өмнөх сараас 3.9 хувиар буурахад хонь, ямааны махны үнэ дунджаар 6.8 хувь, үхрийн махны үнэ 1.8 хувь, адууны махны үнэ 0.1 хувиар, харин өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буурахад хонь, ямааны махны үнэ 7.3 хувь, адууны махны үнэ 6.1 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хот:


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2022 оны 10 дугаар сард өмнөх сараас 0.9 хувь, өмнөх оны эцсээс 10.9 хувь, өмнөх оны мөн үеэс 14.6 хувиар өслөө.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 14.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 15.5 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 9.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 20.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 23.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 29.3 хувь, тээврийн бүлгийн үнэ 5.3 хувь, боловсролын бүлгийн үнэ 10.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 17.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 10 дугаар сард өмнөх оны эцсээс 10.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 9.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 6.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 18.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 19.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 22.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 10 дугаар сард өмнөх сараас 0.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 1.6 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 0.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.6 хувь, тээврийн бүлгийн үнэ 0.3 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

ЗУРАГ 44. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС сараар (өмнөх оны мөн үеэс), хувиар




Улаанбаатар хотод 2022 оны 10 дугаар сард хэрэглээний сагсны 404 нэрийн бараа, үйлчилгээнээс 125 (30.9%) нь үнэ өмнөх сараас өсөж, 21 (5.2%) нь үнэ буурч, 258 (63.9%) нь үнэ өөрчлөлтгүй байна.

ЗУРАГ 45. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЦУЛ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ 2022 оны 10 дугаар сард 15640 төгрөг болж, 2020 оны 10 дугаар сараас 23.5 хувь, 2021 оны 10 дугаар сараас 3.7 хувиар өсөж, өмнөх сараас 217 (1.4%) төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 46. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 10 дугаар сард 13562 төгрөг болж, 2020 оны 10 дугаар сараас 26.9 хувь, 2021 оны 10 дугаар сараас 2.1 хувиар өсөж, өмнөх сараас 168 (1.2%) төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 47. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр



Улаанбаатар хотод худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 10 дугаар сард 10238 төгрөг болж, 2020 оны 10 дугаар сараас 19.7 хувиар өсөж, 2021 оны 10 дугаар сараас 7.0 хувиар, өмнөх сараас 784 (7.1%) төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 48. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ НЭГ ЛИТР АИ-92 БЕНЗИНИЙ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ 2022 оны 10 дугаар сард 2390 төгрөг болж, 2020 оны 10 дугаар сараас 66.9 хувь, 2021 оны 10 дугаар сараас 16.7 хувиар өссөн байна.

Аймаг:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 10 дугаар сард бүх аймагт өмнөх оны мөн үеэс 10.7-17.0 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 10 дугаар сард Баян-Өлгий аймагт 10.7 хувиар өссөн нь хамгийн бага, Дорнод аймагт 17.0 хувиар өссөн нь хамгийн их байна.


ЗУРАГ 49. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 2022 оны 10 дугаар сард (өмнөх оны мөн үеэс), хувь, аймаг, нийслэлээр



Аймгуудад худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 10 дугаар сард 8671 төгрөг болж, 2021 оны 10 дугаар сараас 636 төгрөгөөр буурсан байна.

Хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2022 оны 10 дугаар сард Говь-Алтай аймагт 7402 төгрөг байгаа нь хамгийн бага, Булган аймагт 10084 төгрөг байгаа нь хамгийн их байна.

ЗУРАГ 50. АЙМГУУДАД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 10 дугаар сард, төгрөгөөр



Ойлголт, тодорхойлолт

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

Хэрэглээний үнийн индексийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейрсийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – тайлант үеийн хувиргасан Ласпейрсийн индекс (t)

t – тайлант үе

i – бараа, үйлчилгээ

o – суурь үе

P_{it} - i барааны тайлант үеийн үнэ

P_{io} - i барааны суурь үеийн үнэ

Q_{io} - i барааны суурь үеийн жин

Хэрэглээний үнийн индексийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг.

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 404 бараа, үйлчилгээ (аймагт 313 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2018, 2019, 2020 оны дундаж үр дүнгээр жинг тооцон, 2020 оны шинэчилсэн суурьтайгаар 2022 оны 8 дугаар сараас эхлэн тархааж байна.

Хэрэглээний үнийн индексийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан. Мөн аймгийн дундаж үнийг тооцохдоо сонгогдсон 112 сумын үнийн мэдээллийг хамруулж байна.



Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн барааны үнийг сум, аймаг, дүүрэг, нийслэлээс сар бүр цуглуулж байна.




Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2022 оны 9 дүгээр сард өмнөх сараас 18.2 хувиар буурсан байна

Гадаад худалдааны нөхцөлийн индекс (2015=100) 2022 оны 9 дүгээр сард 149.0 болж, өмнөх оны мөн үеэс 24.4 хувь, өмнөх оны эцсээс 19.8 хувь, өмнөх сараас 18.2 хувиар тус тус буурсан байна.

Экспортын үнийн индекс (2015=100) 2022 оны 9 дүгээр сард 181.6 болж, экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 12.0 хувь, өмнөх оны эцсээс 16.1 хувь, өмнөх сараас 16.8 хувиар тус тус буурсан байна. Экспортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар буурахад эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 12.6 хувиар (төмрийн хүдэр, зэсийн баяжмал, чулуун нүүрс) буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин өмнөх сараас 16.8 хувиар буурахад эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 17.7 хувиар (чулуун нүүрс, төмрийн хүдэр, түүхий нефть, зэсийн баяжмал) буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Импортын үнийн индекс (2015=100) 2022 оны 9 дүгээр сард 121.9 болж, импортын үнэ өмнөх оны мөн үеэс 16.4 хувь, өмнөх оны эцсээс 4.6 хувь, өмнөх сараас 1.7 хувиар тус тус өссөн байна. Импортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 16.4 хувиар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 41.7 хувиар (нефть, цемент) өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин өмнөх сараас 1.7 хувиар өсөхөд тээврийн хэрэгслийн бүлгийн үнэ 19.6 хувиар (суудлын машин) өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 51. ГАДААД ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛИЙН ИНДЕКС (2015=100), хувиар



Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индексийг экспортын үнийн ерөнхий индексийг импортын үнийн ерөнхий индексэд харьцуулж тооцно.

Экспортын үнийн индекс: Монгол Улсын экспортын голлох худалдааны түнш орнуудад нийлүүлж буй барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.

Импортын үнийн индекс: Монгол Улсын худалдааны түнш орнуудаас импортолж буй гол нэрийн барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.

Суурь үе: Индекс тооцоход хугацааны бусад үеийн үзүүлэлтэд харьцуулж тооцох хугацаа юм.






Хязаалан гунан үхрийн үнэ Говьсүмбэр аймагт хамгийн өндөр буюу 1.9 сая төгрөг байна

Малын зах зээлийн дундаж үнийн 2022 оны 10 дугаар сарын мэдээллийг өмнөх сартай харьцуулахад хязаалан гунан үхрийн үнэ 1.3 сая төгрөг болж, 9.0 мянган төгрөгөөр өссөн бол атны үнэ 1.4 сая төгрөг болж, 22.0 мянган төгрөгөөр, соёолон үрээний үнэ 1.1 сая төгрөг болж, 12.1 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 194.2 мянган төгрөг болж, 11.7 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 138.4 мянган төгрөг болж, 3.9 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 52. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ (сум), мянган төгрөгөөр




Хязаалан гунан үхрийн үнэ 2022 оны 10 дугаар сард Говьсүмбэр аймагт хамгийн их буюу 1.9 сая төгрөг, Баян-Өлгий аймагт хамгийн бага буюу 857.7 мянган төгрөг байна.

ЗУРАГ 53. ХЯЗААЛАН ГУНАН ҮХРИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 10 дугаар сард, мянган төгрөг




Үхрийн 2 метрээс дээш урттай шир 2022 оны 10 дугаар сард 6.3 мянган төгрөг болж, өмнөх сараас 0.5 мянган төгрөгөөр өссөн бол цагаан ноолуурын 1 кг-ын дундаж үнэ 91.1 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.7 мянган төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 54. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 10 дугаар сард, төгрөгөөр



Цагаан ноолуурын 1 кг-ын дундаж үнэ 2022 оны 10 дугаар сард Улаанбаатар хот, Завхан, Өвөрхангай болон Дорноговь аймгуудад хамгийн их буюу 100.0 мянган төгрөг, Баян-Өлгий, Булган болон Орхон аймгуудад хамгийн бага буюу 80.0 мянган төгрөг байна.

ЗУРАГ 55. ЦАГААН НООЛУУРЫН 1 КГ-ЫН ДУНДАЖ ҮНЭ, 2022 оны 10 дугаар сард, төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.






Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх сараас 3.8 хувиар өссөн байна

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100) 2022 оны 10 дугаар сард урьдчилсан гүйцэтгэлээр 208.5 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 22.1 хувь, өмнөх сараас 3.8 хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 56. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100), сараар, хувиар



Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2022 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 22.1 хувиар өсөхөд уул уурхай, олборлолтын дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 24.1 хувиар (нүүрс олборлолтынх 55.6 хувь, уул уурхай, олборлолтын туслах бусад үйл ажиллагааны олборлолтынх 53.1 хувь, газрын тос, олборлолтынх 34.7 хувь, бусад ашигт малтмал олборлолтынх 19.1 хувь, металлын хүдэр олборлолтынх 13.1 хувь) өссөнөөс шалтгаалсан байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2022 оны 10 дугаар сард өмнөх сараас 3.8 хувиар өсөхөд уул уурхай, олборлолтын дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 4.4 хувиар (газрын тос, олборлолтынх 11.3 хувь, бусад ашигт малтмал олборлолтынх 4.6 хувь, уул уурхай, олборлолтын туслах бусад үйл ажиллагааны олборлолтынх 2.5 хувь, металлын хүдэр олборлолтынх 1.3 хувь, нүүрс олборлолтынх 1.2 хувь) өссөн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 34. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТӨД ДЭД САЛБАРУУДЫН ОРОЛЦОО, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар, нэгж хувиар

Дэд салбар	2020 X		2021 X		2022 X	
	хувь	нэгж хувь	хувь	нэгж хувь	хувь	нэгж хувь
Ерөнхий индекс	-12.7	100.0	37.4	100.0	22.1	100.0
Уул уурхай, олборлолт	-13.7	107.6	36.7	98.1	19.9	90.2
Боловсруулах үйлдвэрлэл	0.7	-5.6	0.7	1.9	2.4	10.8
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.2	-1.9	-0.1	-0.3	-0.4	-1.8
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.0	0.0	0.1	0.4	0.2	0.8

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 22.1 хувиар өсөхөд уул уурхай, олборлолтын салбарын үйлдвэрлэгчийн үнэ 19.9 нэгж хувь, боловсруулах үйлдвэрийн салбарынх 2.4 нэгж хувь, усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарынх 0.2 нэгж хувиар нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 35. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, 2022 оны 10 дугаар сард, дэд салбараар, хувиар

Дэд салбар	Нийт жин	2022* X 2015	2022* X 2021 X	2022* X 2022 IX
	2015=100			
Ерөнхий индекс	100.0	208.5	122.1	103.8
Уул уурхай, олборлолт	77.9	224.7	124.1	104.4
Боловсруулах үйлдвэрлэл	14.6	164.8	120.5	104.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	6.7	116.0	92.0	89.4
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.8	209.2	123.1	100.0

Ойлголт, тодорхойлолт:

Үйлдвэрлэгчийн үнийн индекс: Тухайн үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн болон худалдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

Индексийн жин: Индексийн тооцоонд ашиглах жинг тухайн бүтээгдэхүүний нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувийн жингээр тооцно.

Тооцох аргачлал:

Үйлдвэрлэгчийн үнийн индексийн тооцоонд Ласпейрсийн үнийн индексийг ашиглана. Үүнд:

$$I_P^t = \frac{\sum_{i=1}^n (p_t^i * q_0^i)}{\sum_{i=1}^n (p_0^i * q_0^i)}$$

Үүнд:

I_P^t – t тайлант үеийн Ласпейрсийн үнийн индекс

t – тайлант үе

0 – суурь үе

p_t^i – i барааны тайлант үеийн үнэ

p_0^i – i барааны суурь үеийн үнэ

q_0^i – i барааны суурь үеийн худалдан авсан тоо





Барилгын өртөг өмнөх улирлаас 8.3 хувиар өссөн байна


Барилгын өртгийн ерөнхий индекс (2015=100) 2022 оны 3 дугаар улиралд 221.9 болж, барилгын өртөг өмнөх оны мөн үеэс 23.4 хувь, өмнөх улирлаас 8.3 хувиар өслөө.

Орон сууцны барилгын өртгийн индекс (2015=100) 2022 оны 3 дугаар улиралд 261.3 болж, өртөг нь өмнөх оны мөн үеэс 28.6 хувь, өмнөх улирлаас 8.5 хувиар өссөн байна. Орон сууцны барилгын өртөг өмнөх улирлаас 8.5 хувиар өсөхөд материалын өртөг 8.3 хувь, машин механизмын түрээсийн зардал 14.9 хувь, цалингийн зардал 7.6 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Орон сууцны бус барилгын өртгийн индекс (2015=100) 2022 оны 3 дугаар улиралд 215.9 болж, өртөг нь өмнөх оны мөн үеэс 22.5 хувь, өмнөх улирлаас 8.2 хувиар өссөн байна. Орон сууцны бус барилгын өртөг өмнөх улирлаас 8.2 хувиар өсөхөд сургуулийн барилгын өртөг 9.4 хувь, эмнэлэг, сувиллын барилгын өртөг 5.7 хувь, конторын барилгын өртөг 11.8 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Инженерийн барилга, байгууламжийн өртгийн индекс (2015=100) 2022 оны 3 дугаар улиралд 160.1 болж, өртөг нь өмнөх оны мөн үеэс 12.1 хувь, өмнөх улирлаас 9.6 хувиар өссөн байна. Инженерийн барилга, байгууламжийн өртөг өмнөх улирлаас 9.6 хувиар өсөхөд авто замын байгууламжийн өртөг 10.0 хувь, эрчим хүчний байгууламжийн өртөг 6.9 хувиар өссөн нь нөлөөлжээ.

ЗУРАГ 57. БАРИЛГЫН ӨРТГИЙН ИНДЕКС (2015=100), улирлаар, хувиар



ХҮСНЭГТ 36. БАРИЛГЫН ӨРТГИЙН ИНДЕКС, дэд салбараар, хувиар

Дэд салбар	2022 VII-IX 2015	2022 VII-IX 2021 VII-IX	2022 VII-IX 2021 X-XII	2022 VII-IX 2022 IV-VI
	2015=100			
Ерөнхий индекс	221.9	123.4	121.9	108.3
Орон сууцны барилга	261.3	128.6	124.2	108.5
Орон сууцны бус барилга	215.9	122.5	121.8	108.2
Инженерийн барилга, байгууламж	160.1	112.1	111.9	109.6

Ойлголт, тодорхойлолт:

Барилгын өртгийн индекс: Барилга, байгууламжийг барьж байгуулахад зарцуулж буй барилгын материал, машин, механизм, цалингийн үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

Барилгын төрөл: Барилгын төрлийг орон сууцны барилга, орон сууцны бус барилга, инженерийн барилга, байгууламж гэж хуваана.

Тооцох аргачлал:

Барилгын материал, цалин, машин, механизмын жинг тооцон, сонгогдсон барилгын материалын үнэ, машин, механизмын тариф цалинг цуглуулж, тус бүрийн индексийг тооцно. Индексийг тооцохдоо Ласпейрсийн үнийн индексийн томъёог ашиглана.

$$I_1 = \frac{\sum P_1 Q_0}{\sum P_0 Q_0}$$

P_0 - суурь үеийн үнэ,

P_1 - тайлант үеийн үнэ,

Q_0 - суурь үеийн тоо, хэмжээ







ГАЗАР ТАРИАЛАН, жил бүрийн 10 сарын эцэст

ᠲᠠᠷᠢᠶ᠋ᠠᠯᠠᠨ
ᠭᠠᠰᠠᠷ


ХУРААСАН ҮР ТАРИА, мянган тонн




ХУРААСАН ТӨМС, мянган тонн




ХУРААСАН ХҮНСНИЙ НОГОО, мянган тонн



БЭЛТГЭСЭН ХАДЛАН, мянган тонн



БЭЛТГЭСЭН ГАР ТЭЖЭЭЛ, мянган тонн





Хураасан үр тариа өмнөх оны мөн үеэс 152.4 мянган тонн буюу 26.9 хувиар буурлаа

Ургац хураалтын явцын мэдээгээр улсын хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын байдлаар 413.9 мянган тонн үр тариа, 211.2 мянган тонн төмс, 139.8 мянган тонн хүнсний ногоо, 153.3 мянган тонн таримал тэжээл, 46.7 мянган тонн техникийн ургамал хурааж, 869.9 мянган тонн хадлан, 28.8 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн байна.

Өмнөх оны мөн үеэс төмс 33.2 (18.7%) мянган тонноор, хүнсний ногоо 25.4 (22.2%) мянган тонноор, техникийн ургамал 6.8 (17.0%) мянган тонноор тус тус өсөж, харин хураасан үр тариа 152.4 (26.9%) мянган тонноор, таримал тэжээл 113.9 (42.6%) мянган тонноор, бэлтгэсэн хадлан 239.7 (21.6%) мянган тонноор тус тус буурсан байна.

Хураасан үр тарианы 4.8-41.3 хувь Хэнтий, Дархан-Уул, Дорнод, Булган, Төв, Сэлэнгэ аймагт, төмсний 2.0-63.8 хувь Өвөрхангай, Баян-Өлгий, Дархан-Уул, Ховд, Сэлэнгэ, Төв аймагт, хүнсний ногооны 5.2-35.6 хувь тус тус Орхон, Ховд, Дархан-Уул, Төв, Сэлэнгэ аймагт ногдож байна.

ХҮСНЭГТ 37. ХУРААСАН УРГАЦ, БЭЛТГЭСЭН ӨВС ХАДЛАН, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2019 Х	2020 Х	2021 Х	2022 Х	<u>2022 Х</u> 2021 Х
	мянган тонн				хувь
Үр тариа	397.2	393.9	566.4	413.9	73.1
Төмс	189.2	241.3	178.0	211.2	118.7
Хүнсний ногоо	91.1	109.8	114.4	139.8	122.2
Таримал тэжээл	109.0	166.6	267.2	153.3	57.4
Техникийн ургамал	27.5	20.8	39.9	46.7	117.0
Бэлтгэсэн хадлан	1 130.4	968.9	1 109.6	869.9	78.4

Хураасан үр тариа Ховд, Баян-Өлгий, Дорнод, Дархан-Уул, Хэнтий аймагт өмнөх оны мөн үеэс 9.8 тонноос 7.3 мянган тонноор (0.5% - 2.6 дахин) өсөж, бусад аймагт 3.7 тонноос 77.9 мянган тонноор (2.4% - 78.8%) буурсан байна.

Хураасан төмс Дорноговь, Ховд, Дундговь, Өвөрхангай, Увс, Дархан-Уул, Баян-Өлгий, Улаанбаатар хот, Сэлэнгэ, Төв аймагт 16.4-31.0 мянган тонноор (0.3% - 2.4 дахин) өсөж, бусад аймагт 37.3 тонноос 1.2 мянган тонноор (3.3% - 45.8%) буурсан байна.

Хүнсний ногоо Өвөрхангай, Говь-Алтай, Баянхонгор, Дархан-Уул, Өмнөговь, Архангай, Завхан, Хөвсгөл аймагт 69.6-485.7 тонноор (1.2% - 33.2%) буурч, бусад аймагт 16.4 тонноос 17.7 мянган тонноор (4.3% - 2.4 дахин) өссөн байна.

Техникийн ургамал Өвөрхангай, Увс, Төв аймагт 155.0 тонноос 2.4 мянган тонноор (20.8% - 82.7%) буурч, бусад аймагт 68.0 тонноос 3.1 мянган тонноор (13.7% - 4.0 дахин) өссөн байна.

Таримал тэжээл Говьсүмбэр, Ховд, Баян-Өлгий, Улаанбаатар хот, Сэлэнгэ аймагт 27.6 тонноос 7.4 мянган тонноор (3.9% - 43.1 дахин) өсөж, бусад аймагт 0.2 тонноос 74.4 мянган тонноор (18.2% - 87.9%) буурсан байна.

Бэлтгэсэн хадлан Улаанбаатар хот, Говь-Алтай, Завхан, Сэлэнгэ, Увс, Дорнод аймагт 177.1 тонноос 33.1 мянган тонноор (1.8% -47.9%) өсөж, харин бусад аймагт 15.2 тонноос 115.1 мянган тонноор (0.3% -90.6%) буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Тариалсан талбай гэж хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.

Нийт хураасан ургац нь тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг таримал ургамлын хэмжээгээр тодорхойлогдоно.


Га-гийн ургац гэж талбайн нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ юм. Га-гийн ургацыг тодорхойлохдоо хураасан ургац (үр тариа, төмс)-ын хэмжээг тариалсан талбайд харьцуулж тооцно.





БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, 2022* оны эхний 9 сарын байдлаар

Орion т Fөөсөгөлдө, Yөнт Jасөвр Iia Fөjiй





Барилга угсралт, их засварын ажил 2022 оны эхний 9 сард 30.5 хувиар өслөө

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2022 оны эхний 9 сард 4.6 их наяд төгрөг болж, 4.5 (97.5%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 115.2 (2.5%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.


ХҮСНЭГТ 38. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, гүйцэтгэгчийн төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Үзүүлэлт	2019 I-Х	2020 I-Х	2021 I-Х	2022* I-Х	<u>2022* I-Х</u> 2021 I-Х
	тэрбум төгрөг				хувь
Нийт	3 929.4	4 328.7	3 508.6	4 580.0	130.5
Дотоодын байгууллага	3 667.9	4 243.1	3 421.5	4 464.9	130.5
Төрийн	89.8	388.7	264.4	103.9	39.3
Хувийн	3 558.5	3 794.5	3 120.5	4 324.0	138.6
Гадаадтай хамтарсан	19.6	59.8	36.6	37.0	101.0
Гадаадын байгууллага	261.5	85.6	87.2	115.2	132.1

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2022 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 1.1 (30.5%) их наяд төгрөгөөр өсөхөд дотоодын байгууллагын барилгын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 1.0 (30.5%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

Дотоодын барилгын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 4.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.2 (38.6%) их наяд төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагынх 37.0 тэрбум төгрөг болж, 366.0 (1.0%) сая төгрөгөөр өслөө. Харин төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 103.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 160.5 (60.7%) тэрбум төгрөгөөр тус буурсан байна.

ЗУРАГ 58. БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, төрлөөр, тэрбум төгрөг, жил бүрийн эхний 9 сарын байдлаар




Энэ оны эхний 9 сард барилга угсралт, их засварын ажлын 38.5 хувийг орон сууцны барилга, 28.2 хувийг орон сууцны бус барилга, 30.1 хувийг инженерийн барилга, байгууламж, 3.2 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оны мөн үеэс орон сууцны барилгын ажлын эзлэх хувь 2.4 нэгж хувиар, их засварын ажлынх 0.7 нэгж хувиар, инженерийн барилга, байгууламжийнх 1.4 нэгж хувиар тус тус өссөн бол, орон сууцны бус барилгынх 4.5 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 39.ОРОН СУУЦНЫ БУС БАРИЛГЫН ГҮЙЦЭТГЭЛ, төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Үзүүлэлт	2019 I-Х	2020 I-Х	2021 I-Х	2022* I-Х	<u>2022* I-Х</u> 2021 I-Х
	тэрбум төгрөг				хувь
Орон сууцны бус барилга	1 805.4	1 457.9	1 148.0	1 290.4	112.4
Үйлдвэрийн	937.3	536.1	564.3	496.3	88.0
Худалдаа, үйлчилгээний	104.8	125.2	99.9	143.2	143.3
Эмнэлгийн	102.0	75.6	46.7	51.8	110.9
Сургууль, соёлын	420.4	441.1	275.2	313.1	113.8
Бусад	240.9	279.9	161.9	285.9	176.7

Орон сууцны бус барилгын ажлын гүйцэтгэл 2022 оны эхний 9 сард 1.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 142.4 (12.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд үйлдвэрийн барилгын ажил 68.0 (12.0%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч сургууль, соёлын барилгын ажлынх 37.9 (13.8%) тэрбум төгрөгөөр, худалдаа, үйлчилгээний барилгын ажлынх 43.3 (43.3%) тэрбум төгрөгөөр, бусад орон сууцны бус барилгынх 124.1 (76.7%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 5.1 (10.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

ЗУРАГ 59. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, тэрбум төгрөгөөр



Улаанбаатар хотод 2022 оны эхний 9 сард 2.0 их наяд төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 45.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.7 нэгж хувиар өссөн байна.

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2022 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр Дорноговь

аймагт 941.6 тэрбум төгрөг, Өмнөговь аймагт 601.2 тэрбум төгрөг, Орхон аймагт 146.1 тэрбум төгрөг, Дархан-Уул аймагт 114.8 тэрбум төгрөг болж, энэ нь аймгуудын барилга угсралтын ажлын дүнд 40.4 хувийг эзэлж байна. Дорноговь аймагт Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын барилгын ажил, Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт Оюу толгойн далд уурхайн ажил, төмөр зам болон автозамын ажлууд, Дархан-Уул аймагт автозамын ажлууд, Орхон аймагт Эрдэнэт үйлдвэрийн барилгын өргөтгөлийн ажил, орон сууцны барилга зэрэг ажлууд эрчимтэй хийгдсэн байна.

Ойлголт, тодорхойлолт

Барилга угсралт, их засвар гэж барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг ойлгоно.

Орон сууцны барилга нь хамгийн багадаа түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг байгууламж юм.

Орон сууцны бус барилгад барилгын багахан хэсгийг (нийт талбайн 50%-иас бага хэсэг) орон сууцны зориулалтаар ашигладаг барилгыг оруулна.

Инженерийн барилгын ажилд төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, ус хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга байгууламжийн бүх ажлыг оруулна.





ДОТООД ХУДАЛДАА, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, тэрбум төгрөгөөр

ᠳᠣᠲᠣᠨᠠᠳᠤ ᠬᠤᠳᠠᠯᠳᠠᠭ᠎ᠠ

Нийт борлуулалт



2021* I-IX **19 925.8**

2022* I-IX **26 580.8**

Бөөний худалдаа



2021* I-IX **7 857.6**

2022* I-IX **10 849.7**

Жижиглэн худалдаа



2021* I-IX **12 068.1**

2022* I-IX **15 731.1**



Дотоод худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 33.4 хувиар өслөө

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны эхний 9 сард 26.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.7 (33.4%) их наяд төгрөгөөр өслөө.

Худалдааны салбарын борлуулалтын орлогын 22.2 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 77.8 хувийг хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт эзэлж байна.

Хүнсний бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа 2022 оны эхний 9 сард 5.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 923.7 (18.5%) тэрбум төгрөгөөр, хүнсний бус бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа 20.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.7 (38.4%) их наяд төгрөгөөр тус тус өслөө. Хүнсний бус бүтээгдэхүүний өсөлтөд шатахууны жижиглэн худалдаа 6.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.3 (60.3%) их наяд төгрөгөөр, шатахууны бөөний худалдаа 3.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.6 (86.5%) их наяд төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 40. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО¹, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Үзүүлэлт	2020		2021		2022*		2022* ИХ	
	ИХ	ИХ	ИХ	ИХ	ИХ	ИХ	2021 ИХ	
	тэрбум төгрөг							хувь
Нийт	2 087.2	16 171.2	2 496.0	19 925.8	3 331.7	26 580.8	133.4	
Бөөний худалдаа	803.8	6 162.8	941.7	7 857.6	1 300.8	10 849.7	138.1	
Жижиглэн худалдаа	1 283.5	10 008.4	1 554.3	12 068.1	2 030.9	15 731.1	130.4	

¹ Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэсэн тооцоо

Худалдааны салбарын 2022 оны эхний 9 сарын борлуулалтын орлогын 40.8 хувь нь бөөний худалдаа, 59.2 хувь нь жижиглэн худалдааны салбарт ногдож байна.

Жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2022 оны эхний 9 сард 15.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.7 (30.4%) их наяд төгрөг, харин бөөний худалдааны 10.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.0 (38.1%) их наяд төгрөгөөр тус тус өслөө.

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны 9 дүгээр сард 3.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 14.8 (0.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна.


ЗУРАГ 60. ХУДАЛДААНЫ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, сараар



Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны 9 дүгээр сард өмнөх сараас буурахад төрөлжсөн бус барааны бусад дэлгүүрийн жижиглэн худалдаа 85.0 (14.9%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Аймгуудын худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны эхний 9 сард, өмнөх оны мөн үеэс 9.6-81.4 хувиар өссөн байна.

ЗУРАГ 61. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, аймгаар, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Худалдааны салбарын нийт борлуулалт нь тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалт бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно.







НИЙТИЙН ХООЛ, ЗОЧИД БУУДАЛ, 2022 оны эхний 9 сард, тэрбум төгрөг

НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ОРЛОГО, төрлөөр

■ Баар ■ Гуанз ■ Катеринг ■ Кафе ■ Ресторан



ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ОРЛОГО, зэрэглэлээр






Нийтийн хоолны салбарын орлого өмнөх сараас 0.5 хувиар өсжээ

Нийтийн хоолны салбарын орлого 2022 оны эхний 9 сард 746.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 292.7 (64.5%) тэрбум төгрөгөөр өсжээ. Үүнд рестораны орлого өмнөх оны мөн үеэс 201.7 (78.1 %) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийтийн хоолны салбарын орлого 2022 оны 9 дүгээр сард 93.9 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 492.8 (0.5%) сая төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 62. НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ОРЛОГО, төрлөөр, тэрбум төгрөг, жил бүрийн эхний 9 сарын байдлаар



Нийтийн хоолны салбарын орлогод рестораны орлогын эзлэх хувь 2022 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 4.7 нэгж хувь, баарных 1.6 нэгж хувиар өсөж, харин захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлогын эзлэх хувь 5.5 нэгж хувь, кафеных 0.7 нэгж хувиар, гуанзных 0.2 нэгж хувиар тус тус буурсан байна.


Зочид буудлын салбарын орлого өмнөх сараас 1.5 хувиар өсжээ

Зочид буудлын салбарын орлого 2022 оны эхний 9 сард 266.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 121.2 (83.4%) тэрбум төгрөгөөр өсжээ. Үүнд 3, түүнээс дээш одтой буудлын орлого 90.1 (95.2 %) тэрбум төгрөг, зэрэглэлгүй зочид буудал болон амралтын газрынх 28.0 (58.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зочид буудлын салбарын орлого 2022 оны 9 дүгээр сард 37.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 559.7 (1.5%) сая төгрөгөөр өссөн байна. Үүнд 3, түүнээс дээш одтой буудлын орлого 3.1 (13.0%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Харин зэрэглэлгүй зочид буудал, амралтын газрын орлого 2.5 (1.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зочид буудлын салбарын 2022 оны эхний 9 сарын нийт орлогын 69.4 хувийг 3, түүнээс дээш одтой зочид буудал, 28.4 хувийг зэрэглэлгүй зочид буудал, амралтын газар, 2.2 хувийг 2 одтой зочид буудлын орлого тус тус эзэлж байна.

ЗУРАГ 63. ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ОРЛОГО, ЗЭРЭГЛЭЛЭЭР, тэрбум төгрөг, жил бүрийн эхний 9 сарын байдлаар



Ойлголт, тодорхойлолт:

Нийтийн хоолны салбарт ресторан, кафе, баар, гуанз, захиалгат хоол хүргэх, үйлчлэх үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулна.

Зочид буудлын үйл ажиллагаанд зочид буудал, амралтын газар, хүүхдийн зуслан, түр хоноглох байруудын үйл ажиллагаа хамрагдана.





Объектын түймэр 2022 оны эхний 10 сарын байдлаар 2548 удаа бүртгэгдсэн байна

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2022 оны эхний 10 сарын байдлаар 3547 болж, өмнөх оны мөн үеэс 344 (10.7%)-өөр өссөн байна. Объектын түймэр 2022 оны эхний 10 сард 2548 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 436 (20.6%)-гаар, биологийн гаралтай аюулт үзэгдэл 174 болж, 97 (2.3 дахин их)-гоор тус тус өссөн байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 10 сарын байдлаар нийт 228 хүн амь насаа алдаж, өмнөх оны мөн үеэс 58 (20.3%)-аар буурсан байна.

ХҮСНЭГТ 41. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ², жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	2019 I-X	2020 I-X	2021 I-X	2022 I-X	2022 I-X
					2021 I-X
					хувь
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	4 317	3 660	3 203	3 547	110.7
Газар хөдлөлтийн тоо	34	48	282	62	22.0
Объектын түймрийн тоо	3 611	2 752	2 112	2 548	120.6
Амь насаа алдсан хүний тоо	187	232	286	228	79.7
Учирсан хохирол, тэрбум төгрөг	48.1	108.2	20.7	27.5	132.9
Зарцуулсан зардал, тэрбум төгрөг	1.1	0.3	1.1	3.1	2.8 ¹

¹ - Дахин их

² - Корона вируст халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны эхний 10 сарын байдлаар 27.5 тэрбум төгрөгийн хохирол учирч, 3.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хэлнэ.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.




МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГА



Б.БАТДАВАА

2022 оны 11 дүгээр сарын 17



ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

I. ХӨДӨЛМӨР

- 1.1. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ, хүйсээр, улирлаар
- 1.2. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ, бүс, аймаг, нийслэлээр, 2022 оны 3 дугаар улиралд
- 1.3. АЖИЛЛАХ ХҮЧ, бүс, аймаг, нийслэлээр, улирлаар
- 1.4. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, бүс, аймаг, нийслэлээр, улирлаар
- 1.5. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧИД, бүс, аймаг, нийслэлээр, улирлаар
- 1.6. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧИД, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, улирлаар
- 1.7. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧИД, хөдөлмөр эрхлэлтийн статусын ангиллаар, улирлаар
- 1.8. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ, бүс, аймаг, нийслэлээр, улирлаар
- 1.9. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, бүс, аймаг, нийслэлээр, улирлаар
- 1.10. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, бүс, аймаг, нийслэлээр, улирлаар
- 1.11. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШИН, бүс, аймаг, нийслэлээр, улирлаар
- 1.12. НЭГ АЖИЛЛАГЧИД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, 2015 оны зэрэгцүүлэх үнээр

II. ӨРХИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

- 2.1. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, эх үүсвэр, улсын дунджаар
- 2.2. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГЫН БҮТЭЦ, эх үүсвэр, улсын дунджаар
- 2.3. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, зарлагын төрөл, улсын дунджаар
- 2.4. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГЫН БҮТЭЦ, зарлагын төрөл, улсын дунджаар
- 2.5. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, эх үүсвэр, суурьшлаар, 2022 оны 3 дугаар улиралд

2.6. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГЫН БҮТЭЦ, эх үүсвэр, суурьшлаар, 2022 оны 3 дугаар улиралд

2.7. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, зарлагын төрөл, суурьшлаар, 2022 оны 3 дугаар улиралд

2.8. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГЫН БҮТЭЦ, зарлагын төрөл, суурьшлаар, 2022 оны 3 дугаар улиралд

2.9. МӨНГӨН ОРЛОГЫН БҮЛЭГЛЭЛТ, өрхийн дүнд эзлэх хувь, суурьшлаар, 2022 оны 3 дугаар улиралд

2.10. МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮЛЭГЛЭЛТ, өрхийн дүнд эзлэх хувь, суурьшлаар, 2022 оны 3 дугаар улиралд

III. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

3.1. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО, оны үнээр

3.2. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, үйлдвэрлэлийн аргаар, улирлаар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр

3.3. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, эцсийн ашиглалтын аргаар, улирлаар, оны үнээр

3.4. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, эцсийн ашиглалтын аргаар, улирлаар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр

IV. МӨНГӨ, ЗЭЭЛ, ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

4.1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ¹, сар бүрийн эцэст

4.2. БАНКУУДЫН НЭГДСЭН ТАЙЛАН ТЭНЦЭЛ, сар бүрийн эцэст

4.3. АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, зээлийн ангиллаар, сар бүрийн эцэст

4.4. ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН НЭРЛЭСЭН ХАНШ, сарын дундаж

4.5. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сар бүрийн эцэст

4.6. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн 7 дугаар сарын эцэст

4.7. ИДЭВХТЭЙ АРИЛЖСАН ҮНЭТ ЦААС, сарын эцэст

4.8. ХАНШ НЬ ХАМГИЙН ИХ ӨССӨН ҮНЭТ ЦААС, 2022 оны 10 дугаар сарын эцэст

4.9. ХАНШ НЬ ХАМГИЙН ИХ БУУРСАН ҮНЭТ ЦААС, 2022 оны 10 дугаар сарын эцэст

V. ТӨСӨВ

5.1. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

5.2. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

5.3. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

5.4. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН АЛДАГДЛЫН САНХҮҮЖИЛТ, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

5.5. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

5.6. УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

5.7. УЛСЫН ТӨСВИЙН АЛДАГДЛЫН САНХҮҮЖИЛТ, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

5.8. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

5.9. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

5.10. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН АЛДАГДЛЫН САНХҮҮЖИЛТ, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

5.11. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар

5.12. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

5.13. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

5.14. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

5.15. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

VI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

6.1. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

6.2. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, дэлгэрэнгүй ангиллаар

VII. ГАДААД ХУДАЛДАА

7.1. ГАДААД ХУДАЛДААНЫ НИЙТ ЭРГЭЛТ

7.2. ЭКСПОРТ, улсаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

7.3. ЭКСПОРТ, барааны бүлгээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

7.4. ЭКСПОРТЫН ЗАРИМ НЭРИЙН БАРАА, улсаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

7.5. ЭКСПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

7.6. ИМПОРТ, улсаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

7.7. ИМПОРТ, барааны бүлгээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

7.8. ИМПОРТЫН ЗАРИМ НЭРИЙН БАРАА, улсаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

7.9. ИМПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

7.10. ЭКСПОРТ, улсаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

7.11. ИМПОРТ, улсаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

7.12. ГАДААД ХУДАЛДАА, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

VIII. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

8.1. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН УЛСЫН ИНДЕКС, барааны бүлэг, дэд бүлгээр

8.2. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН БҮСИЙН ИНДЕКС, бараа, үйлчилгээний бүлгээр

8.3. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, бараа, үйлчилгээний бүлэг, дэд бүлгээр

8.4. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, бараа, үйлчилгээний нэр төрлөөр

8.5. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, өмнөх сартай харьцуулснаар, бараа, үйлчилгээний бүлэг, дэд бүлгээр, аймгаар

8.6. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, өмнөх оны эцэстэй харьцуулснаар, бараа, үйлчилгээний бүлэг, дэд бүлгээр, аймгаар

8.7. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, бараа, үйлчилгээний бүлэг, дэд бүлгээр, аймгаар

8.8. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хүнсний гол нэрийн барааны үнэ, аймаг, нийслэлээр

8.9. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хүнс, хүнсний бүс бараа, үйлчилгээний бүлэг, дэд бүлгээр, аймгаар

8.10. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС бараа, үйлчилгээний бүлгээр, хувиар, улс, бүсээр

8.11. ГАДААД ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛИЙН ИНДЕКС, сараар, хувиар

8.11.1. ЭКСПОРТЫН ҮНИЙН ИНДЕКС¹, барааны бүлгээр, сараар, хувиар

8.11.2. ИМПОРТЫН ҮНИЙН ИНДЕКС¹, барааны бүлгээр, сараар, хувиар

8.12. ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ

8.12.1. МАЛАЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, аймаг, нийслэлээр, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар

8.12.2. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, аймаг, нийслэлээр, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар

8.13. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, дэд салбараар, хувиар, 2022 оны 10 дугаар сард

8.14. БАРИЛГЫН ӨРТГИЙН ИНДЕКС

IX. ГАЗАР ТАРИАЛАН

9.1. ХУРААСАН ҮР ТАРИА, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар

9.2. ХУРААСАН ТӨМС, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар

9.3. ХУРААСАН ХҮНСНИЙ НОГОО, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, ЖИЛ БҮРИЙН 10 ДУГААР САРЫН БАЙДЛААР

9.4. ХУРААСАН ТАРИМАЛ ТЭЖЭЭЛ, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар

9.5 ХУРААСАН ТЕХНИКИЙН УРГАМАЛ, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар

9.6. БЭЛТГЭСЭН ХАДЛАН, ГАР ТЭЖЭЭЛ, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар

X. БАРИЛГА

10.1. БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, дотоод, гадаадын барилгын байгууллагаар

10.2. БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, барилгын төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

10.3. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

XI. ДОТООД ХУДАЛДАА

11.1. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ¹, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

XII. ЗОЧИД БУУДАЛ, ЗООГИЙН ГАЗАР

12.1. НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН НИЙТ ОРЛОГО, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

12.2. ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН НИЙТ ОРЛОГО, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

XIII. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

13.1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ, жил бүрийн эхний 10 сарын байдлаар



nso.mn

Холбоо барих

14200 Улаанбаатар, Монгол Улс, Засгийн Газрын III байр, 306 тоот



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212